

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ		
ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ	оны.....-р сарынөдөр
Бэлтгэн нийлүүлэгч байгууллага /хувь хүн/-ний мэдээлэл	Нэр	"Зам тээврийн хүрээлэн" ТББ
	Банкны нэр	Хаан Банк
	Дансны дугаар	5041351921
Төлбөрийн мэдээлэл	Зориулалт	Техникийн зориулалтаар бэлтгүүлж зөвлөх үйлчилгээний элчийн хэргийг санхүүжилт
	Төлөх дүн	2'840'000.00 төгрөг
ЗӨВШӨӨРСӨН		ХҮСЭЛТ ГАРГАСАН:
Захирал..... огноо.....	/Гарын үсэг/ огноо.....	Хэлтсийн нэр..... ЗТТЧСННХ.....
		Хэлтсийн дарга:/нэр/огноо..... 2019.02.01.
		Хүсэлт гаргасан: Д.Бадарсаг /нэр/огноо.....
ХЯНАСАН:		
Ерөнхий Ня-Бо...../гарын үсэг/ огноо.....		

Төлбөрийн хүсэлтийг хүлээн авч бичилт хийсэн:

Нягтлан бодогч...../нэр/ огноо.....



"ЗАМ, ТЭЭВРИЙН ХҮРЭЭЛЭН"
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
"Этүгэн" группын 2-р байр 03 тоот
Утас: 99213311, Э-Шуудан: zikhureelen@gmail.com

2013.12.24 № 12/03

№

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ Р.БУД ТАНАА

Оюунбат

*Сүхбаатар сансраа
Тамгын тусгаар*

*Оюунбат
2013.12.24*

Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ байгуулсны дагуу бид [Авто тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгааны ажил] –ын эхлэлийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Холбогдох шатны санхүүжилтийг олгож өгөхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ОЮУНБАТ

Оюунбат

*Сүхбаатар сансраа
Тамгын тусгаар*

2013.12.24

**“АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ,
ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА”-НЫ АЖЛЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛИЙН ШАТНЫ ТАЙЛАНД
РЕДАКЦИ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ**

2019.01.28

Улаанбаатар хот

1. ОРШИЛ

Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгаа”-ны ажлын зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал 2018.08.31-нд баталсан байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээг захиалагч “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /цаашид Захиалагч гэх/ ба зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч “Зам, тээврийн хүрээлэн” НҮТББ /цаашид Зөвлөх гэх/ -ийн хооронд 2018.11.23-ны өдөр байгуулсан байна.

Дээр дурдсан гэрээний тусгай нөхцөлийн 2.2-т эхлэлийн тайланг 2018.12.24-нд танилцуулахаар заасны дагуу Зөвлөх тайланг 2018.12.24-ний 12/03 тоот албан бичгээр Захиалагчид ирүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулан Захиалагч гэрээт ажлын эхлэлийн шатны тайланд редакци шүүмж хийх ажлын хэсгийг томилсон бөгөөд эхлэлийн шатны тайланг ажлын даалгаврын хамт ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, санал авсны үндсэн дээр энэхүү дүгнэлтийг боловсруулав.

2. ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тайланг Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, Оршил, Судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ, аргачлал болон Авто тээврийн салбарын эрх зүйн орчны судалгаа, Техникийн зохицуулалт гэсэн хоёр бүлэг, Хавсралтын хамт боловсруулжээ.

Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөнд Монгол улсын авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдлын талаарх эрх зүйн судалгаа, үйлдвэрлэл, худалдааны талаар олон улсад мөрдөгдөж буй баримт бичгийн судалгаа, Авто замын тээвэртэй холбоотой импорт, худалдааны өнөөгийн байдал, авто замын тээвэртэй холбоотой нэр томъёо, тодорхойлолт, татвар, даатгал, бүртгэлийн системүүдийн талаарх судалгаа, санал техникийн зохицуулалтыг боловсруулах болон тайланг бичиж, хүлээлгэн өгөх, хэлэлцүүлэх зэрэг нийт 19 бүлэг ажлыг 9 сарын хугацаанд хийхээр тусгасан байна.

Судалгааны ажлын зорилгод “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг боловсруулах, түүнтэй холбоотой хийгдэх судалгаа, боловсруулалтын ажлыг багцлан хийхээр тусгасан байна.

Судалгааны ажлын хамрах хүрээг тогтоохдоо Монгол улсын төрөөс авто тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг, Замын хөдөлгөөний аюулгүй үндэсний стратегийг баримталж улс, бүс, олон улсын хэмжээний харьцуулсан судалгааг хийж, зөвлөмж гаргах, Монгол улсын авто замын тээврийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, эрх зүйн холбогдох баримт бичгийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ хийх, дүгнэлт санал боловсруулах, Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэх талаар зөвлөмж боловсруулахаар төлөвлөсөн байна.

Судалгааны ажлын арга зүйг боловсруулахдаа судалгааны ажлын хүрээ, материал, аргачлал гэж бүлэглэн авч үзсэн байна.

Авто тээврийн салбарын эрх зүйн орчны судалгаа гэсэн нэгдүгээр бүлэгт, Авто тээврийн салбарт нэгдэн орсон конвенци, Засгийн газар хоорондын хэлэлцээр, Их хурал болон Засгийн

газраас баталсан хууль тогтоомж болон бусад эрх зүйн бичиг баримт, авто тээврийн салбарт мөрдөгдөж буй стандарт зэрэг жагсаалтыг гаргаж, авто замын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын өнөөгийн байдалд 2017 он хүртлэх тоо, мэдээнд тулгуурлан судалгаа хийсэн байна.

Техникийн зохицуулалт гэсэн хоёрдугаар бүлэгт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол улсын хуулийн хоёрдугаар бүлгийг оруулсан байна.

Эцэст нь хавсралтад, Австрали улсын тээврийн хэрэгслийн стандартыг Монгол хэлээр орчуулсныг оруулсан байна.

3. АЖЛЫН ХЭСГИЙН САНАЛ

Зөвлөхийн гэрээт ажлын эхлэлийн тайлантай Ажлын хэсгийн гишүүд танилцаад дараах санал, зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

- Төслийн ажлын даалгавар болон ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөнд тусгагдсан хугацаат ажлуудын агуулга, багтаамж, хамрах хүрээг сайжруулах;
- Зөвлөх үйлчилгээний хүрээнд Авто замын тээврийн хэрэгслийг үйлдвэрлэх, ашиглах, борлуулах, техникийн үйлчилгээ хийхтэй холбоотой 1958, 1997, 1998 оны Женевийн конвенци, түүнийг дагаж гарсан техникийн зохицуулалтын талаар судалгаа хийх. Учир нь эдгээр НҮБ-ээс гаргасан 142 орчим техникийн зохицуулалт нь тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд тавигддаг шаардлагыг багцлан гаргасан байдаг;
- “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг боловсруулахын өмнө Монгол улсад импортоор орж ирж буй тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэгч голлох улс орнуудыг тогтоож тэдгээрийн мөрдөж буй эрх зүйн баримт бичгийг судалж, Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарттай харьцуулж дүн шинжилгээ хийх;
- Техникийн зохицуулалтын төслийн боловсруулалтын ажил эхэлсэн үед ажлын даалгаврын хүрээнд редакц шүүмж хийх;
- Хавсралт хэсэгт Австрали улсын стандартыг оруулсан шалтгаан, учир холбогдлыг гаргах, техникийн зохицуулалт боловсруулах, судалгааны ажилд ашиглах тохиолдолд орчуулгын үг, үсэг, утгын алдааг засварлах, нэр, томъёо, тодорхойлолтыг Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, баримт бичигтэй ижилсүүлэх, дэлгэрэнгүй төлөвлөгөөндөө мэргэжлийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах заалтыг оруулж, хэлэлцүүлгийг 2-оос доошгүй удаа хийх (ажлын даалгаварт тусгагдсаны дагуу);
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн:
 - 13.1.Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино.
 - 13.2.Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна.
 - 13.4.Энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Монгол улсын Засгийн газрын “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” 2018 оны 291 дүгээр тогтоолоор “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ыг шинэчлэн

баталсан байна. Уг жагсаалтад нийтийн тээврийн үйлчилгээ хамрагдсан байна.

Иймд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх бус харин тохирлын үнэлгээнд заавал хамруулахаар гарсан Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх шаардлагыг тусгах;

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн:
 - 13.1.Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино.
 - 13.2.Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна.
 - 13.4.Энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Монгол улсын Засгийн газрын “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” 2018 оны 291 дүгээр тогтоолоор “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ыг шинэчлэн баталсан байна.

Уг жагсаалтад моторт тээврийн хэрэгслийн эд анги, тоног хэрэгсэл, тоормос болон серво-тоормос; эдгээрийн эд анги, хурдны хайрцаг болон түүний эд анги, цохилт-зөөллөгч систем болон түүний эд анги, амортизатор, жолооны хүрд, жолооны гол, жолооны механизм, эдгээрийн эд анги, авто тээврийн хэрэгсэл үйлдвэрлэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл хамрагдсан байна.

Иймд тохирлын үнэлгээнд эдгээр бүтээгдэхүүнийг заавал хамруулахаар гарсан Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх шаардлагыг тусгах;

- Авто тээврийн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийн жагсаалтад 2018 онд батлагдсан “Төрөөс авто тээврийн салбарт баримтлах бодлого” (2018-2026), Төрөөс авто тээврийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тусгах.

Уг жагсаалтын 29, 30, 31 хэсэгт байгаа журмууд дараах байдлаар шинэчлэгдэн батлагдсан тул өөрчлөх:

- 29. Зам, тээврийн сайдын тушаалаар Тээвэрлэлттэй холбоотой баримт хэвлүүлэх журмыг шинэчлэн баталсан;
- 30. Зам, тээврийн сайдын 2013 оны 232 дугаар тушаалаар Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журмыг шинэчлэн баталсан;
- 31. Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дугаар тушаалаар Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг шинэчлэн баталсан;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2018 онд Стандартын улсын үзлэг явуулах дэд ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс авто тээврийн салбарт мөрдөгдөж буй стандартыг судлан үзэж 112 стандарт мөрдөгдөж байна гэж үзсэн тул судалгааны ажилд тусгах;
- Үйлдвэрлэгч, экспортлогч орнууд болон хөрш зэргэлдээ орнуудад дагаж мөрдөж буй эрх зүйн баримт бичигтэй харьцуулсан Монгол улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын судалгаа, эрх зүйн баримт бичгийг боловсруулан хүрэх үр дүнг тодорхойлох гэсэн 2 ажлын гүйцэтгэл хангалтгүй байгааг анхаарах.

4. АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

- ❖ Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг дараагийн шатны тайланд тусгах
- ❖ Дунд шатны тайланг хүлээн авч судалсны дараа ажлын хэсэг, зөвлөхийг оролцуулсан хамтарсан хурал зохион байгуулах

- ❖ Эхлэлийн шатны тайлангийн гүйцэтгэлийг хангалттай гэж үзэж байгаа тул гэрээний үнийн 10%-тэй тэнцэх 2'840'000 төгрөгийн санхүүжилтийг нэхэмжлэхийн дагуу Зөвлөхөд олгох

Ажлын хэсгийн ахлагч:


М.Ган-Эрдэнэ



“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга угсралтын хяналтын хэлтсийн дарга


Гишүүд:

Ц.Нэргүйбаатар



Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн

Н.Зориг



“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын дарга

И.Базаррагчаа



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн Тээврийн салбарын эрхлэгч, доктор /Ph.d/

Нарийн бичиг:

Э.Агиймаа



“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн мэргэжилтэн

**“АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА”-
НЫ АЖЛЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХЛЭЛИЙН ШАТНЫ ТАЙЛАН
ХҮЛЭЭЛЦСЭН АКТ**

2019.01.31

Улаанбаатар хот

“Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2018-2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгаа”-ны ажлын зөвлөх үйлчилгээг “Зам, тээврийн хүрээлэн” НҮТББ /О.Оюунбат/ гүйцэтгэн, эхлэлийн шатны тайланг Захиалагчид хүлээлгэн өгөв.

Ажлын тайланг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 2018/287 дугаар гэрээний тусгай нөхцөлийн 2.2-т заасан хугацаанд дараах хэлбэрээр хүлээн авлаа. Үүнд:

- Тайлангийн эх хувийг хэвлэмэл хэлбэрээр – 1%
- Тайлангийн эх хувийг цахим хэлбэрээр – 1%

Иймд эхлэлийн шатны тайлан, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Захирлын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 тоот тушаалаар байгуулагдсан редакцийн ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлийн 6.4 (1)-т заасны дагуу гэрээний үнийн 10%-тэй тэнцэх дүн болох 2,840,000 төгрөгийг Зөвлөхөд олгох нь зүйтэй гэж үзлээ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын:

“Зам, тээврийн хүрээлэн” НҮТББ-ын:

Захирал



Р.БУД

Зураг төслийн магадлал, стандарт, норм
нормативын хэлтсийн дарга

Р.БАДАМХАНД

Захиргаа санхүүгийн хэлтсийн нягтлан
бодогч

З.ЗОЛЖАРГАЛ

Зураг төслийн магадлал, стандарт, норм
нормативын хэлтсийн мэргэжилтэн

Д.БАЗАРСАД

Гүйцэтгэх захирал




О.ОЮУНБАТ

Төслийн менежер

Ч.БАТБАЯР

БАТЛАВ.



“АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2018 оны 11-р сарын 23-ны өдөр

Дугаар № 2018/287 Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороонд байршилтай “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Зам, тээврийн хүрээлэн” НҮТББ (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 11 сарын 23-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан Зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгаа” ЗҮ-8 зөвлөх үйлчилгээний ажлыг (цаашид “ажил” гэх) 28,400,000 /хорин найман сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Хавсралт
 - Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
 - Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь
 - Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь
 - Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг
5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.


6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
9. Энэхүү гэрээг 2018 оны 11 –р сарын 23-ны өдөр 3 хувь үйлдэж, захиалагчид 2 хувь, Зөвлөхөд 1 хувийг хадгалав.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Зам, тээврийн хөгжлийн төвийн Зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга

 Р.БАДАМХАНД

Зам, тээврийн хөгжлийн төвийн Төлбөр авах нэгж хариуцсан нягтлан бодогч бөгөөд нягтлан бодогчийн үүргийг хавсран гүйцэтгэгч

 З.ЗОЛЖАРГАЛ

Зам, тээврийн хөгжлийн төвийн Хуулийн асуудал, гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

 Ч.САРУУЛ

Захиалагчийн хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, "Зам, тээврийн хөгжлийн төв"
ТӨҮГ-ын төв байр,
Утас: 70001150

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Зам, тээврийн хүрээлэн" НҮТББ
гүйцэтгэх захирал


О.ОЮУНБАТ

Төслийн менежер,
Ч.БАТБАЯР

Гүйцэтгэгчийн хаяг: Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 41-10 тоот

Утас: 99213311, 99100945

Данс: Хаан банк, 5041351921

I. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1.1 Нэр томъёоны тайлбар

- 1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (a) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
 - (б) “ Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
 - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
 - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
 - (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
 - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
 - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
 - (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “ Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
 - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
 - (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
 - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
 - (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
 - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 - (ө) “Ажиллах хүчин ” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.



- 1.2 **Гэрээнд хэрэглэгдэх хууль** Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3 **Гэрээнд ашиглах хэл** Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 1.4 **Мэдэгдэл** Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 **Байршил** Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харъяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 **Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ** Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 **Итгэмжлэгдсэн төлөөлөгч** Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 **Татвар, хураамж** Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 **Авилгал болон залилан мэхлэх үйлдэл** Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
- Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авилгын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- 2.1 **Гэрээ хүчин төгөлдөр болох** Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 **Үйлчилгээг эхлэх** Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.



- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох** ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
- 2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар** Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
- 2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**
- 2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.
- 2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

2.6 Гэрээ цуцлах

- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах** Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
- (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
- (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол;
- (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;

2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй

- (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрайн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй:

2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс:
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч букуу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

3.2 Ашиг сонирхлын зөрчил

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих



ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

- 3.3 Нууцлал** Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй
- 3.4 Зөвлөхийн хариуцах даатгал** Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
- 3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа** Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:
- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
 - (б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
 - (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
- 3.6 Тайлагнах хуваарь** Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.
- 3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь** Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
- 3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит** Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт** Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих** (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү

буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.

- (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох
Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт
Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.
- 5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө
Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр
Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ
 - (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
 - (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
- 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр
ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.

- 6.4 Төлбөр хийх нөхцөл. хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.
- ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.
- 6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү** Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

7. ШУДАРГА БАЙДАЛ

- 7.1 Шударга байдал** Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх** Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 8.2 Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчилнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон бусад эрх зүйн актууд.
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	<p>Захиалагчийн хаяг: <i>Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын төв байр,</i> <i>Шуудангийн хаяг: СХД, Монгол шуудан 21-р салбар,</i> Захиалагч: <i>"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ</i> Харилцах хүн: <i>Стандарт, норм норматив хариуцсан мэргэжилтэн Д.Базарсад</i> Утас: <i>70001150</i></p> <p>Зөвлөх: <i>"Зам, тээврийн хүрээлэн" НҮТББ</i> Харилцах хүн: <i>О.Оюунбат</i> Гүйцэтгэгчийн хаяг: <i>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 41-10 тоот</i> Данс: <i>Хаан банк, 5041351921</i> Утас: <i>99213311, 99100945</i></p>
1.8	Татвар: Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч нь тухайн ажлыг гүйцэтгэх явцад гарах бүх татвар, төлбөр, хураамж, шимтгэлийг тооцож "Санхүүгийн санал"-даа тусгасан байна. Орхигдуулсан тохиолдолд захиалагч хариуцахгүй болно.
2.2	<p>Гэрээт ажлыг эхлүүлэх хугацаа: 2018 оны 11 –р сарын 23 –ны өдөр</p> <p>Эхлэлийн тайлан: 2018 оны 12 –р сарын 24 –ны өдөр</p> <p>Дунд шатны тайлан: 2019 оны 03 –р сарын 15 –ны өдөр</p> <p>Эцсийн шатны тайлан: 2019 оны 07 –р сарын 01 –ны өдөр</p>
2.3	<p>Тогтоосон хугацаа: 2019 оны 08 –р сарын 01 –ны өдөр.</p> <p>Зөвлөх нь тогтоосон хугацаанд Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хожимдуулсан хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги тооцно.</p> <p>Алдангийн хэмжээ Гүйцэтгээгүй үүргийн дүнгийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй. Алданги төлснөөр Зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөхгүй.</p>
3.4	Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: Даатгалын тусгайлсан шаардлага байхгүй. Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх явцад аливаа даатгалын зардлыг зөвлөх хуулийн этгээд бүрэн хариуцна.
6.2 (a)	Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн дээд хэмжээ: Гадаад мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо хийхгүй.

6.2 (б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: Бүх төлбөр тооцоог Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгтээр Төгрөгөөр хийнэ.
6.4	<p>Төлбөр хийх данс: <i>Хаан банк, 5041351921</i> Төгрөгийн хувьд: <i>Зам, тээврийн хүрээлэн НҮТББ</i></p> <p>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</p> <p>(1) Хүлээн зөвшөөрөхүйц (эхлэлийн шатны тайлангийн дүгнэлт гарсан байх) эхлэлийн шатны тайлангийн төслийг захиалагч акт үйлдэн хүлээн авч, баталгаажсанаас хойш 28 хоногийн дотор төлөх дүн: <i>[Гэрээний үнийн 10 % буюу 2 840 000 төгрөг];</i></p> <p>(2) Хүлээн зөвшөөрөхүйц (дунд шатны тайлангийн дүгнэлт гарсан байх) дунд шатны тайлангийн төслийг захиалагч акт үйлдэн хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор төлөх дүн: <i>[Гэрээний үнийн 40 % буюу 11 360 000 төгрөг];</i></p> <p>(3) Хүлээн зөвшөөрөхүйц эцсийн тайланг (Редакцийн ажлын хэсгийн эцсийн дүгнэлт, эцсийн шатны тайлангийн дүгнэлт гарсан байх) захиалагч акт үйлдэн хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор төлөх дүн: <i>[Гэрээний үнийн 30 % буюу 8 520 000 төгрөг];</i></p> <p>(4) Баримт бичгийг Зам, тээврийн салбарын Шинжлэх Ухаан технологийн зөвлөлийн хурлын шийдвэр гарсны дараа төлөх дүн: <i>[Гэрээний үнийн 20 % буюу 5 680 000 төгрөг];</i></p>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Захиалагч болон Зөвлөх нь Монгол Улсын Хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй болно.



ТАЙЛАН ӨГӨХ ГРАФИК

Ажлыг дуусгаж тайлан өгөх

	Тайлан	Он, сар, өдөр
1	Эхлэлийн тайлан	2018.12.24.
2	Явцын тайлан	2019.03.15.
4	Эцсийн тайлан	2019.07.01.

"Зам, тээврийн хүрээлэн"
НҮТББ-ын Гүйцэтгэх захирал



О.ОЮУНБАТ

Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
8-р хороо "Этүгэн" группын
2-р байр 03 тоот



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

Нэр		Албан тушаал	Сарууд (хөндлөн зураасаар тэмдэглэх)						Хүн сар
			2018 он		2019 он				
			1	2	2	3	4	5	
Үндсэн ажилтан	Ж.Сэрээтэр	Тэргүүн							8
	О.Оюунбат	Гүйцэтгэх захирал							8
	Ч.Батбаяр	Судлаач							8
Дотоодын судлаачид	Ч.Ганбат	Судлаач							6
	Ц.Алтанцэцэг	Судлаач							6
	Х.Булгаа	Судлаач							6
	С.Сийлэгмаа	Орчуулагч							4
Гадаадын зөвлөх	Jaе Hong Kap	Зөвлөх							3
НИЙТ									49


Үндсэн ажилтнаар: 3

Дотоодын судлаач: 4

Гадаад зөвлөх: 1

Тайлангийн тоо: эхний, дундын, эцсийн тайлан

Гүйцэтгэх хугацаа: 2019 оны II улирал

.....

 О.ОЮУНБАТ/

“Зам, тээврийн хүрээлэн”
 НҮТББ-ын Гүйцэтгэх захирал

Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
 8-р хороо “Этүгэн” группын
 2-р байр 03 тоот



ЗАРДЛЫН ТОВЧОО

Төслийн гүйцэтгэх хугацааг 8 сараар, ажилтнуудын цалинг ажиллах хугацаа, оролцоогоор бодон тооцоход нийт 28.4 сая төгрөгөөр төслийг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна: Үүнд:

№	Зардал	Баллор	Дүн төгрөгөөр
1	Цалин	8,400 usd	21,600,000
2	Мэдээлэл цуглуулах, судалгааны ажлын зардал	390 usd	1,000,000
3	Төсөлд шүүмж хийлгэх зардал	310 usd	800,000
4	Харилцаа холбоо, бичиг хэргийн зардал	620 usd	1,600,000
5	Дотоодын татвар хураамж	930 usd	2,400,000
6	Бусад зардал	400 usd	1,000,000
		111,050 usd	28,400,000

“Зам, тээврийн хүрээлэн”
НҮТББ-ын Гүйцэтгэх захирал



О.ОЮУНБАТ

Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
8-р хороо “Этүгэн” группын
2-р байр 03 тоот



УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000093525

2014.12.25

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9071054028

/ Улсын бүртгэлийн дугаар /

8160686

/ Регистрийн дугаар /

Замтээврийн хүрээлэн

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2014.12.24

/ Шийдвэрийн нэр /

/ Дугаар /

/ он, сар, өдөр /

Зам тээврийн салбарыг хөгжүүлэх талаар судалгаа, шинжилгээний ажил хийх, төсө
хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, ижил зорилготой байгууллагуудтай
хамтран ажиллах

9499

/ КӨД /

/ Ингэсан эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ КӨД /

/ Гуслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

20.00

/ Хугацаа /

/ Хуулийн этгээдийн тоо /

/ Өөрийн хөдөлгөөний хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар Банкнурх, 26-р хороо дунжингарав 102 10 /сст, утас1 99103502 Утас2, Факс,

/ хуулийн этгээдийн албан ёсны хэл /





/ Хуулийн этгээдийн анбан өсвийн хэлтэс /

Улаанбаатар Банкны 26-р хороо /Увсжийн талбай 102 10 нөср, Утас 99103502 Утас, Факс

/ Өөрийн хөрөнгийн хэлтэс, мөнгө, үнэмлэхүүн /

/ Хуульч /

/ Хуульч /

20.00

1

Хуульч

/ Гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Ингэн эргүүлж үйл ажиллагааны чиглэл /

/ код /

Хамтран ажиллах

5.99

Эм тээврийн сэлбэрийг хөгжүүлэх талаар судалгаа, шинжилгээний ажил хийж, төсө хөтөлбөр хэрэгжүүлэх, суртал зохирсон байгуулах, ижил зорилготой байгууллагуудыг

/ Он, сар, өдөр /

/ Оунар /

/ Тээвэр /

2014.12.24

01

Шийдвэр

/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Дүрэм

/ Хуулийн этгээдийн нэр, харуулганы нэр /

Ингэн эргүүлж үйл ажиллагааны чиглэл

Эм тээврийн хурал

/ Өөрийн хөрөнгийн оунар /

8160688

/ Өөрийн хөрөнгийн оунар /

9071054028

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

2014.12.25

0000093525

МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТЭРЧИЛЭЭ



УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000093525

2014.12.25

/Бүртгэсэн өг. сар өдөр /

9071054028

/Улсын бүртгэлийн дугаар /

8160686

/Регистрийн дугаар /

Замтээврийн хүрээлэн

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

/Хуулийн этгээдийн нэр, тариуцлагын үзлээр /

Дүрэм

/Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2014.12.24

/Шийдсэнийгч нэр /

/дугаар /

/сн, сар, өдөр /

Зам тээврийн салбарыг хөгжүүлэх талаар судалгаа, шинжилгээний эжил хийх төсө
хөтөлбөр хэрэгжүүлэх, суртал зохисон байгуулах, ижил зэрэглэлтэй байгууллагуудыг
хамтран ажиглах

5-195

/Нэсэн эрхлэх үйл ажиллагааны нэвтрэл /

/көб /

/Гуулах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Аугацаагүй

1

20.00

/Ауулаа /

/Хуулийн этгээдийн нэр /

/Улсын бүртгэлийн хэлтэс, төлөв, дугаар /

Улаанбаатар Баянзүрх 26-р хороо Хүн-Ажилчид 102 10 тоот, утас 99103502 Утас2, факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хөтөлгөө /





АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА"-
НЫ АЖЛЫН ДААЛГАВАР

2018 оны 8 сарын 31-ны өдөр

№ 2018/АД-008

Улаанбаатар хот

1. Төсөл боловсруулах үндэслэл

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;
- Монгол Улсын Шадар Сайдын 2016 оны 119 дүгээр тушаалаар батлагдсан "Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 104 дүгээр заалт;
- "Авто замын норм, нормативын сан"-ийн хөрөнгөөр 2018-2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө

2. Төслөөр шийдвэрлэх асуудал

"Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг боловсруулахтай холбоотой олон улсын эрх зүйн бичиг, туршлагыг судлан Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн нийцүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, зөвлөмж боловсруулах;
"Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төсөл боловсруулах;

3. Төслийн иж бүрдэл

Техникийн зохицуулалт"-ыг боловсруулан батлуулж, дагаж мөрдөх чиглэлээр судалгаа хийж, үр дүнг судлан, зөвлөмж боловсруулан байна.

- Үйлдвэрлэгч, экспортлогч орнууд болон хөрш зэргэлдээ улсад дагаж мөрдөж байгаа эрх зүйн баримт бичигтэй харьцуулан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын судалгаа;
- Хүн ам, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хэрхэн бууруулах талаарх судалгаа
- Эрх зүйн баримт бичгийг боловсруулан хүрэх үр дүнг тодорхойлох;
- Судалгааны ажлыг боловсруулах явцад 2-оос доошгүй удаа хэлэлцүүлэг зохион байгуулж,

Стандартчилал хэмжилзүйн газар болон холбогдох төрийн болон ТББ-уудаас санал авч тусгана.

- Судалгааны ажлын эцсийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны ШУТЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
- Судалгааны ажлын тайланг "Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц, шаардлага." MNS 2492:2004 стандартын дагуу гүйцэтгэнэ.

"Авто тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг дараах бүтэцтэй байна.

- Авто тээврийн хэрэгслийн олон улсын ангилал тус бүрт тавигдах шаардлага нэр томъёо, тодорхойлолт, хэмжээ, жин, даацын ерөнхий шаардлага
- Авто тээврийн хэрэгсэл, түүний төрөл тус бүрт тавих ашиглалт, аюулгүй байдлын ерөнхий шаардлага;
- Авто тээврийн хэрэгсэл, түүний эд анги импортлоход тавих ерөнхий шаардлага;
- Авто тээврийн хэрэгсэл, түүний эд анги үйлдвэрлэх, сорилт туршилт хийх, үйлдвэрлэлээс ашиглалтад шилжүүлэхэд тавих ерөнхий шаардлага;
- Бүртгэл мэдээлэл, техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээ, татвар, даатгалын систем гэх мэт.

"Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага

- Техникийн зохицуулалтын нэр томъёо, тодорхойлолтыг олон улсын болон Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцүүлэх ("Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай" Венийн конвенци, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм гэх мэт);
- Дэлхийн худалдааны байгууллагын "худалдаан дахь саад тотгор"-ын хэлэлцээрт нийцүүлнэ.



- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасантай нийцүүлнэ.
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дах заалтад нийцүүлнэ.
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу дүгнэлт гаргуулсан байна.
- Нэр томьёо, тодорхойлолтыг Гадаад харилцааны яамаар хянуулан, орчуулгыг баталгаажуулна.
- Бусад

4.Төслийн үр дүн

"Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгаа"-ны ажил хийгдсэнээр дараах үр дүн гарна.

- Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдлын чиглэлээр олон улсад дагаж мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгийн судалгаа хийгдсэн байна.
Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг олон улсын түвшинд хүргэх чиглэлээр зөвлөмж боловсруулагдсан байна.

"Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг боловсруулан батлуулж, дагаж мөрдөгдөж эхэлсэнээр дараах үр дүн гарна.

- Нэр томьёо, тодорхойлолт олон улсын түвшинд хүрэх;
- Үйлдвэрлэгчийн тохирлын баталгаа, сорилт туршилт хийх, аюулгүй байдал /идэвхтэй, идэвхгүй, экологи/ хангагдана;
- Авто засвар үйлчилгээ хийх, аюултай хог хаягдлыг хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, хоргүйжүүлэх, устгах эрх зүйн орчин бүрдэнэ;
- "Экологийн ангиллын стандарт" буюу Евро-I- Евро-VI хөдөлгүүрт тавих ерөнхий шаардлага, хөдөлгүүрээс ялгарах агаар бохирдуулагч бодис, хорт хаягдал /нүүрсхүчлийн хий, азотын давхар исэл, хүхэр, хар тугалга, хөө тортог,

бусад/-ын зөвшөөрлийг хэлцээ тогтоогдсон байна.

- Замын харгалзаны аюулгүй байдал хангагдана.

- Дэлхийн худалдааны байгууллагын нэгдэн орсон "Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр"-т нийцүүлэн шаардлага бүр хэрэгсэл, түүнийг хэрэгсэх шаардлагад тавих ерөнхий шаардлагын эрхүйн орчин бүрдэнэ.

5.Төсөл хэрэгжүүлэгч

Зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий хуулийн этгээд /Сонгон шалгаруулалтаар/

6.Төслийг хэрэгжүүлэх хугацаа

8 сар /Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш/

7.Төслийн онцгой нөхцөл

Дэлхийн худалдааны байгууллагын "Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, холбогдох олон улсын гэрээ хэлэлцээр болон Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлсэн байна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨЛБӨР АВАХ НЭГЖ, ЗАМЫН АШИГЛАЛТ,
ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАМ, ЗАСВАР АРЧЛАЛТЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ
НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНЧИМЭГ

Ж.БАЯРСАЙХАН

Т.ЧИНТУЯА

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

АВТО ЗАМЫН ХЯНАЛТ, ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ
ТӨВИЙН ЗАХИРАЛ



Р.ОТГОНБААТАР

БАТЛАВ.

ЗӨВЛӨХ КОМПАНИ:

"АР ДИ ЭЙ СИ" ХХК
ЗАХИРАЛ



"Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд үнийн индекс тооцох заавар боловсруулах", "Авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлын суурь норматив" УББ 80-201-00 нормын шинэчлэн боловсруулах, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын жишиг үнэ" БД 81-104-04-ийг шинэчлэн боловсруулах /Жишиг үнийг 14 оны түвшинд тодорхойлох/

ГЭРЭЭ

2014 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар №01

ННС-2014/Б-01.

Улаанбаатар
хот

Нэг талаас **Авто Замын Хяналт, Эрдэм Шинжилгээ Судалгааны Төв** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"Ар Ди Эй Си" ХХК** (цаашид "зөвлөх" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ний өдөр энэхүү **ГЭРЭЭГ** (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралтад тодорхойлсон "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ"-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь **"Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд үнийн индекс тооцох заавар боловсруулах", "Авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлын суурь норматив" УББ 80-201-00 нормын шинэчлэн боловсруулах, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын жишиг үнэ" БД 81-104-04-ийг шинэчлэн боловсруулах /Жишиг үнийг 14 оны түвшинд тодорхойлох/** ажлыг (цаашид "ажил" гэх) **31 100 000 /гучин нэгэн сая нэг зуун мянган төгрөг/** (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ

Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч – Голлох мэргэжилтний ажлын хуваарь

Хавсралт №4 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг

Хавсралт №5 Захиалагчийн хүлээх үүрэг

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АВТО ЗАМЫН ХЯНАЛТ, ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ, СТАНДАРТ, НОРМ
НОРМАТИВ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ГАН-ЭРДЭНЭ

АВТО ЗАМЫН ХЯНАЛТ, ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ, СТАНДАРТ, НОРМ
НОРМАТИВ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.НАРАНБАТ

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"АР ДИ ЭЙ СИ" ХХК-ний
ИНЖЕНЕР

А.ЖАВХЛАНТӨГС

ХАЯГ: УБ хот Хан-Уул дүүрэг
15-р хороо 26-19

Утас: 991666118, 99110615

azolushka@yahoo.com

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХҮРЭЭЛЭН”
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**“АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭХЛЭЛИЙН ТАЙЛАН**



АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажлын жагсаалт	Сарууд /2018-2019/								
		11	12	1	2	3	4	5	6	7
1	Автозамын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдааны талаарх Монгол Улсад мөрдөгдөж буй техникийн бичиг баримтын судалгаа, эрх зүйн орчны өнөөгийн байдал									
2	Автозамын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдааны талаарх олон улсад мөрдөгдөж техникийн бичиг баримтыг судлах									
3	Үйлдвэрлэгч, экспортлогч орнууд болон хөрш зэргэлдээ улсад дагаж мөрдөж байгаа эрх зүйн баримт бичигтэй харьцуулсан Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын судалгаа									
4	Эрх зүйн баримт бичгийг боловсруулан хүрэх үр дүнг тодорхойлох									
5	Автозамын тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн импортын талаарх МУ-ын өнөөгийн нөхцөл байдлыг судлах									
6	Автотээврийн хэрэгслийн олон улсын ангилал тус бүрт тавигдах шаардлага нэр томьёо, тодорхойлолт, хэмжээ, жин, даацын ерөнхий шаардлага									
7	Автотээврийн хэрэгсэл, түүний төрөл тус бүрт тавих ашиглалт, аюулгүй байдлын ерөнхий шаардлага									
8	Автотээврийн хэрэгсэл, түүний эд анги импортлоход тавих ерөнхий шаардлага									
9	Автотээврийн хэрэгсэл, түүний эд анги үйлдвэрлэх, сорилт туршилт хийх, үйлдвэрлэлээс ашиглалтад шилжүүлэхэд тавих ерөнхий шаардлага									
10	Бүртгэл мэдээлэл, техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээ, татвар, даатгалын системийн уялдаа холбоог бүрдүүлэх									

11	Автозамын тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн импортын талаарх МУ-ын өнөөгийн нөхцөл байдлыг судлах												
12	Тээврийн хэрэгслээс үүдэлтэй хүн ам, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хэрхэн буурах талаарх судалгаа												
13	Автозамын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдааны талаарх Монгол Улсын эрх зүйн бичиг баримтуудыг боловсруулах, шинэчлэх талаар санал гаргах												
14	Техникийн зохицуулалтыг олон улсын болон МУ-ын хууль тогтоомж, стандарт, дүрэм журамд нийцүүлэн боловсруулах												
15	Техникийн зохицуулалтын төсөлд төрийн болон ТББ-уудаас санал авах,												
16	Эхний шатны тайлан бичих, хүлээлгэн өгөх												
17	Дунд шатны тайлан бичих, хүлээлгэн өгөх												
18	Эцсийн шатны тайлан бичих, хүлээлгэн өгөх												
19	Судалгааны ажлын эцсийн тайланг ЗТХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх												

АГУУЛГА

1	Оршил	5
2	Судалгааны ажлын зорилго	7
3	Судалгааны ажлын хамрах хүрээ	7
4	Судалгааны арга зүй	8
5	Автотээврийн салбарын эрх зүйн орчны судалгаа	11
6	Авто замын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын өнөөгийн байдал	24
7	Замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт	30
8	Тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, дахин боловсруулалтын үйл ажиллагаа, стандартын шаардлага хангуулахад тавих хяналт	28
9		
10		
11		
12		
13		
14		
Хавсралт		31

ОРШИЛ

Автотээврийн салбарт нэгдэн орсон олон улсын конвенци 3, Засгийн газар хоорондын Автотээврийн харилцааны тухай хэлэлцээр 14, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг 18, 122 стандарт дагаж мөрдөгдөж байгаа хэдий ч Засгийн газраар батлагдан гарсан Техникийн зохицуулалт одоогоор байхгүй байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 900,1 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 58,9 хувь нь Улаанбаатар хотод 41,1 хувь орон нутагт бүртгэлтэй байна. Тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлаас харахад 10-аас дээш насжилттай тээврийн хэрэгсэл 82 хувийг эзэлж байна. Баруун гар талдаа хүрдтэй тээврийн хэрэгсэл нийт тээврийн хэрэгслийн 58 хувийг эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслээс 16 хувь буюу 131573 нь хосолсон, 2,2 хувь буюу 18299 нь хийн, 0,01 хувь буюу 90 нь цахилгаан хөдөлгүүртэй байна.

Монгол Улсад автотээврийн хэрэгслийг шинээр угсарч, үйлдвэрлэж эхэлж байгаа хэдий ч машин үйлдвэрлэлийн эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Одоогоор машин үйлдвэрлэлийн салбарт дараах үндэсний стандартууд мөрдөгдөж байна.

- MNS5773:2007 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800 маркийн троллейбус угсрах, ашиглах. Үндсэн параметрууд ба техникийн ерөнхий шаардлага;
- MNS6225:2010 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800F маркийн доубус. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS6310:2012 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800 маркийн автобус. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS6224:2010 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага;
- MNS6311:2012 Хөдөө аж ахуйн машин техник. МОН-1000-90 загварын будаа ачих машин. Техникийн ерөнхий шаардлага.

Дээрх стандартын дагуу Монгол Улсад 2006 оноос хойш нийт 100 тээврийн хэрэгсэл угсарч үйлдвэрлэсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Автотээврийн тухай хуулиар зохицуулалт байхгүй, харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.15-д төмөрлөг

боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг үйлдвэрлэл, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгохоор заасан байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас нийт 9 аж ахуйн нэгжид төмөрлөг, машин үйлдвэрлэлийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна

Монголын анхны тээврийн байгууллага болох “Улсын тээх нэвтрүүлэх газар”-ыг 1925 онд байгуулж, энэ үеэс бид авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж, ашигласаар ирсэн бөгөөд цаашид үйлдвэрлэх худалдаалах боломж бидний өмнө нээлттэй байгаа тул Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулах нь зүйтэй юм.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГАЧЛАЛЫН ТАЛААР

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлын зорилго нь “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулахтай холбогдуулан олон улсын эрх зүйн бичиг баримт, туршлагыг судлан Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн нийцүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. Мөн Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулахад оршино.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлогын бичиг баримт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний стратеги (2012-2020)-ийг хэрэгжүүлэх, асуудлыг улс үндэсний, (олон улсын түвшинд), бүсийн (хөрш болон бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны хүрээг хамруулан), өөрийн улсын түвшнээр харьцуулан судалж, шийдвэрлэх хувилбаруудыг зөвлөмж хэлбэрээр гаргана.

“Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг боловсруулахтай холбоотой энэхүү судалгааны ажил нь дараах хүрээг хамран хийгдэнэ. Үүнд:

- МУ-ын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
- МУ-ын автотээврийн салбарт мөрдөгдөж байгаа тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, экспорт, импорт, ашиглалт, аюулгүй байдалтай холбоотой хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаж буй байдалд дүн шинжилгээ хийх, холбогдох дүгнэлт, саналыг боловсруулах;
- Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх эрх зүйн бичиг баримтыг олон улсын жишигт нийцүүлэх зөвлөмжийг боловсруулах.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

“Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын судалгаа”-ны ажлыг хийж гүйцэтгэхэд дараах судалгааны болон технологийн үндсэн аргачлалыг баримтлан ажиллана.

А. Судалгааны ажлын аргачлал

Судалгааны ажлыг дараах хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн чиглэлээр;
- 2) авто замын тээврийн хэрэгслийн ашиглалтын чиглэлээр;
- 3) авто замын тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын чиглэлээр;
- 4) авто замын тээврийн хэрэгслийн худалдааны чиглэлээр;
- 5) авто замын тээврийн хэрэгсэлтэй холбогдсон туршилт, судалгааны чиглэлээр
- 6) бусад орнуудын туршлага, мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалтын чиглэлээр;
- 7) Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын чиглэлээр.

Судалгааны ажлын материал нь:

- ✓ Олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны талаарх эрх зүйн бичиг баримтууд;
- ✓ Монгол Улсын авто замын тээврийн хэрэгслийн эрх зүйн бичиг баримтууд, хууль тогтоомж, дүрэм журам, тушаал, шийдвэрүүд;
- ✓ Гадны орнуудын авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны талаарх холбогдох туршилт, судалгаанууд;
- ✓ Гадны орнуудын авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны талаарх зөвлөмжүүд;
- ✓ Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны талаарх хурал, зөвлөгөө, уулзалтын материалууд;
- ✓ Авто замын тээврийн хэрэгсэлтэй холбоотой статистик судалгаа, тайлан;
- ✓ Авто замын тээврийн хэрэгслийн эд ангитай холбоотой статистик судалгаа, тайлан;
- ✓ Олон улс болон МУ-д мөрдөгдөж буй авто замын тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн засвар үйлчилгээний тогтолцоо;

✓ Автомашины дистрибьютр, авто үйлчилгээний байгууллагуудын мэдээ, тайлан, мэдээлэл;

✓ Шинэ техник, технологийн талаарх танилцуулга, илтгэл, тайлан, мэдээлэл;

✓ Судалгаа хийх зааварчилгаа;

✓ Энэ чиглэлээр хийгдэж буй гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрүүд зэрэг нь болно.

Дараах судалгаа, шинжилгээний аргачлалаар холбогдох судалгааг хийж гүйцэтгэнэ:

➤ **Ишлэлийн арга:**

- Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудыг судлах;
- Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны чиглэлээр автомашин үйлдвэрлэгч орнуудын баримталж буй бодлогыг судлах;
- Бусад орны авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны чиглэлээрх эрх зүйн бичиг баримтуудыг судлах;
- Энэ чиглэлээр хийгдсэн шинжлэх ухааны бүтээлүүдийг судлах;

➤ **Статистикийн арга:**

- Холбогдох статистик судалгааг нэгтгэх, дүгнэх /тээврийн хэрэгслийн тоо, тээврийн хэрэгслээс хүний эрүүл мэнд, байгаль болон хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл г.м/;
- Өөрсдийн хийх судалгааны үзүүлэлтүүдийг нэгтгэх;

➤ **Дүн шинжилгээний арга:**

- Нөхцөл байдлын үндэслэл, шаардлагуудыг судлах, тодорхойлох;
- МУ-ын авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны өнөөгийн болон хөгжлийн цаашдын түвшинг судлах, тодорхойлох;
- Бусад орны авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдал, худалдааны өнөөгийн болон хөгжлийн цаашдын түвшинг судлах, тодорхойлох;

- Энэ чиглэлээр хийгдсэн оновчтой эрх зүйн зохицуулалтын үзүүлэх нөлөөллийг тодорхойлох;
- Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалтын үеийн болон ашиглалтаас хасах үеийн сөрөг нөлөөллийг тодорхойлох;
- Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдааны эрэлт хэрэгцээг тодорхойлох, өсөлтийн төсөөллийг гаргах;

➤ **Харьцуулалтын арга:**

- Судалгааны үзүүлэлтүүдийг өөр хооронд нь харьцуулах;
- Гадны орны туршлагыг өөрийн орны онцлог нөхцөлтэй харьцуулах;

Б. Технологийн аргачлал

✓ Тухайн ажлыг эхлэхийн өмнө хийгдэж байсан судалгааны ажлын статистик мэдээлэл, тайланг цуглуулна. Мөн холбогдох олон улсын цахим хуудсанд нэвтрэн интернет судалгаа, статистик мэдээ, тайланг авах;

✓ Бусад орны авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт, аюулгүй байдлыг хангахад тулгарсан бэрхшээл, тэдгээрийн хэрхэн шийдвэрлэсэн талаарх туршлагыг судлах;

✓ Автомашинжилтийн цаашдын хэтийн төлөв зөв, оновчтой хийгдэж байгаа эсэхийг судлах;

✓ Тулгамдсан асуудлуудад үнэлгээ өгөх, шийдвэрлэх арга зам, шийдлүүдийг тогтоох;

✓ Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт, аюулгүй байдлын талаарх олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй нөхцөл шаардлагуудыг хангах талаар санал боловсруулах;

✓ Төслийн үр дүнд үндэслэн холбогдох мэргэжил, арга зүйн зөвлөмжийг боловсруулж, төслийн эцсийн тайланд тусгах;

✓ Авто замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт, аюулгүй байдлын талаарх техникийн бичиг баримттай болно.

Зөвлөхүүдийн зүгээс судалгааны ажлыг хийх явцад судалгаа шинжилгээ хийх нэмэлт арга аргачлал шаардагдахаар бол тухай бүр ашиглаад, боловсруулалт хийх боломжтой. Шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэлтэй холбоотой онолуудад (тухайлбал, цохилтын онол г.м) тулгуурлан холбогдох дүгнэлт саналыг гаргах болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1.1. АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Автотээврийн салбарт нэгдэн орсон олон улсын конвенци 3, Засгийн газар хоорондын Автотээврийн харилцааны тухай хэлэлцээр 14 байгаа бөгөөд шинэчлэх шаардлагатай 2 хэлэлцээр байна.

Олон улсын ачаа тээвэрлэлтийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд “Азийн авто замын сүлжээгээр автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр”-ийг байгуулж, МУ-ын Их Хурлын чуулганы 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар соёрхон баталсан.

Сүүлийн жилүүдэд манай улсын гадаад худалдаа эргэлт өсөн нэмэгдэж байгаатай холбогдон хөрш орнууд төдийгүй гуравдагч орнуудтай автотээврийн харилцааг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Энэ ажлын хүрээнд Бүгд Найрамдах Польш, Чех, Унгар, Гүрж, Словак, Литва, Холбооны Бүгд Найрамдах Герман зэрэг улстай “Авто замаар олон улсын ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулахаар Зам тээврийн хөгжлийн яамнаас ажиллаж байна. Үүний үр дүнд Монголын тээвэрчид Польш, Унгар, Герман, Словак, Унгар зэрэг улсуудад тээвэрлэлт гүйцэтгэх боломж бүрдэнэ.

Автотээврийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш нийт 14 удаа нэмэлт, өөрчлөлт орсны улмаас хуулийн зүйл, заалтын уялдаа холбоо, логик дараалал алдагдсан тул холбогдох хуульд нийцүүлэн Автотээврийн тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүсч байна.

Монгол Улсын эдийн засгийн цар хүрээ тэлж, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжиж байгаа өнөөгийн нөхцөлд автотээврийн ангилал, дамжин өнгөрөх тээвэрлэлт, уул уурхайн тээвэрлэлт, ачаа, зорчигчийн терминал, автомашин үйлдвэрлэл, тээвэр зуучлалын үйлчилгээ, тээврийн даатгал, төрийн хяналт, бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлыг зохицуулж, салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн эрх зүйн шинэтгэл хийх шаардлага гарсан.

Уул уурхайн томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор ашигт малтмалын тээвэрлэлт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх болсон бөгөөд ашигт малтмалыг тээвэрлэх авто замыг аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр барьж, ашиглаж байна.

Нийтийн зорчигч тээвэр нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний амьд явах эрхтэй шууд холбоотой, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах үйл ажиллагаа тул тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгүүлэх нь зүйтэй байна.

Автотээврийн хэрэгслийг шинээр үйлдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, түүнчлэн хуурамч сэлбэг хэрэгслийг улсын хилээр оруулж ирэх, засвар үйлчилгээг стандартын бус нөхцөлд явуулж байгаа зөрчлийг таслан зогсоох зорилгоор авто үйлчилгээ эрхлэгчийг тодорхойлж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030 болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгагдсан зам тээврийн салбарын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, түүнчлэн автотээврийн салбарыг гадаад зах зээлд гаргах, өсөн нэмэгдэж буй тээврийн эрэлт хэрэгцээг хангахын тулд төлөвлөлттэй, бүтээмж өндөртэй, зардал багатай, аюулгүй, шуурхай тээвэрлэлтийн үйлчилгээ шаардлагатай бөгөөд ийм үйлчилгээг хангахын тулд аюулгүй тээврийн хэрэгсэл, дэд бүтцийг бүрдүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад төрийн бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн бичиг баримтууд /нийтлэг байдлаар/

№	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар	Шийдвэр гаргасан субъект
1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	2016.02.05.	19	Монгол Улсын Их хурал
2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	2015.11.26.	-	Монгол Улсын Их хурал
3	Гурван тулгуурт хөгжлийн бодлого	2018.02.06.	42	Засгийн газар
4	Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журам	2016.05.09.	249	Засгийн газар

5	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	2001.06.14	57	Монгол Улсын Их хурал
6	Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр	2010.06.25	36	Монгол Улсын Их хурал
7	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016.09.09.	45	Монгол Улсын Их хурал
8	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	2017.05.01.	42	Монгол Улсын Их хурал
9	Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр 2018-2021	2018.01.31.	36	Засгийн газар
10	"Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"	2016	71	Монгол Улсын Их хурал
11	Монгол Улсын төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого	1998.05.14.	55	Монгол Улсын Их хурал
12	Монгол Улсын төрөөс төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого	2009.10.15.	64	Монгол Улсын Их хурал

**Хүснэгт 2. Автотээврийн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн бичиг
баримтуудын жагсаалт**

№	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар	Шийдвэр гаргасан субект	Цаашид дагаж мөрдүүлэх, шинэчлэх шаардлагатай эсэх талаар тайлбар
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР					
1	Замын хөдөлгөөний тухай 1968 оны Венийн Конвенци	1997.07.09.		МУ-ын ИХ Хурал	-
2	Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенци (1956.05.19)			МУ-ын ИХ Хурал	-
3	ТИР Карнейн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай 1975 оны конвенци			МУ-ын ИХ Хурал 2001-11-10	-
4	Авто тээврээр олон улсын зорчигчид, ачаа тээвэрлэх тухай Монгол Улс, БНКазакстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1993.10.22		МУ-ын Засгийн газар, БНКазУлсын Засгийн газар	шаардлагагүй
5	Авто тээврээр олон улсын зорчигчид, ачаа тээвэрлэх тухай Монгол Улс, БНКазакстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг мөрдөх тухай протокол	1993.10.22		МУ-ын Засгийн газар, БНКазУлсын Засгийн газар	шаардлагагүй.
6	Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс, Украин Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1995.06.27		МУ-ын Засгийн газар, Украин Улсын Засгийн газар	шаардлагагүй.
7	Олон улсын автотээврийн харилцааны тухай Оросын холбооны Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1996.02.07		МУ-ын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт оруулж ажиллах шаардлагатай. мөрдөж
8	Олон улсын автотээврийн харилцааны тухай Оросын холбооны Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг мөрдөх тухай протокол	1996.02.07		МУ-ын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар	Нэмэлт өөрчлөлт оруулж ажиллах шаардлагатай. мөрдөж
9	Тээврийн салбарт хамтарч ажиллах тухай Монгол Улс, БНАСУлсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1996.05.10		МУ-ын Засгийн газар, БНАСУлсын Засгийн газар	Шаардлагагүй.

10	Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол улс, БНТурк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр				Шаардлагагүй.
11	Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс, БНБеларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2003.12.10		МУ-ын Засгийн газар, БНБеларусь Улсын Засгийн газар	Шаардлагагүй.
12	Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс, БНКиргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2004.03.01		МУ-ын Засгийн газар, БНКиргиз Улсын Засгийн газар	Шаардлагагүй..
13	Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2011.06.16		МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар	Шаардлагагүй.
14	Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУ-ын ЗТБХБЯам, БНХАУ-ын ЗТЯам хоорондын протокол	2011.06.16		МУ-ын ЗТБХБЯам, БНХАУ-ын ЗТЯам	Шаардлагагүй.
15	Монгол Улс, Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1991.08.26		БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар	Шаардлагагүй.
16	Монгол Улс, ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1992.10.19		МУ-ын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар	Шаардлагагүй.
17	Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улс, БНКазахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1993.10.22		МУ-ын Засгийн газар, БНКазахстан Улсын Засгийн газар	Шаардлагагүй.
18	"Азийн авто замын сүлжээгээр автотээвэрлэлт гүйцэтгэх тухай" Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2018.4.12.		Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар	Шаардлагагүй.
ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ					
19	Автотээврийн тухай хууль	1999.06.04.		МУ-ын Их хурал	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай

20	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2015.07.08		МУ-ын Их Хурал	Шаардлагагүй
21	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний стратеги /2012-2020/	2012.05.02	146	Монгол Улсын Засгийн газар	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
22	Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого	2008.01.31	12	Монгол улсын Засгийн газар	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
23	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай	2011.07.06	212	Монгол улсын Засгийн газар	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
24	Автотээврийн салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2005.11.08	172	ЗТАЖСайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
25	Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм	2009.08.04	201	ЗТБХБСайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
26	Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам	2009.07.22	188	ЗТБХБСайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
27	Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам, сургалтын хөтөлбөр, үнэмлэхний загвар	2010.05.07	161/ 229	ЗТБХБСайд, БСШУСайдын хамтарсан	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
28	Авто тээврийн жишиг тариф батлах тухай	2008.09.08	136	ЗТАЖСайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
29	Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам	2011.11.03	301	ЗТБХБСайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
30	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам	2010.01.12	06	ЗТБХБ-ын сайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
31	Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам	2010.04.29	128	ЗТБХБ-ын сайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
32	"Жишиг норм батлах тухай"	2004.1.29	19	Дэд бүтцийн хөгжлийн сайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай

33	Дүрэм батлах тухай	1999.04.14.	89/A-55	Дэд бүтцийн хөгжлийн сайд ба НЗД-ын хамтарсан тушаал	Шаардлагагүй
34	Авто зам, замын байгууламжийг хаах, чиглэл өөрчлөх, тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даацад хязгаарлалт хийх журам	2010.04.12.	80	ЗТБХБ-ын Сайд	Шаардлагагүй.
35	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам	2011.03.07.	A/63/67	Байгаль орчин аялал жуулчлалын болон ЗТБХБ-ын сайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
36	Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам	2012.10.29.	59	Зам тээврийн сайд	Шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай
37	Хот хоорондын нийтийн тээврийн чиглэл, чиглэлийн зураглал батлах	2017.11.14.	228	Зам, тээврийн хөгжлийн сайд	Шаардлагагүй.

Хүснэгт 3. Автотээврийн салбарт мөрдөгдөж буй стандартын жагсаалт

№	Стандартууд	Стандартын тэмдэглэгээ
1	Автомашинны техникийн үйлчилгээ. Засвар. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 0012-3-004: 1983
2	Автотээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга	MNS 0017-5-1-21;1992
3	Автомашин, трактор болон ХАА-н машины цонхны болон салхивчийн аюулгүйн шил. Механик шинж чанарыг тодорхойлох арга	MNS 4247:1994
4	Техникийн оношлол. Үндсэн нэр томьёо, тодорхойлолт	MNS 3814:1985
5	Техникийн үйлчилгээ, засварын систем нэр томьёо, тодорхойлолт	MNS 3850:1985
6	Тээврийн хэрэгсэл. Аюулгүйн шил. Ерөнхий техникийн шаардлага	MNS 4246:1994
7	Автотээврийн хэрэгсэл. Дизель хөдөлгүүрээс ялгарах хийг тодорхойлох арга	MNS ISO 7644:1999
8	Автотээврийн хэрэгсэл. Техникийн үзлэг шалгалтаар хорт хийг хэмжих арга	MNS ISO 3929:1999
9	Дотоод шаталтын хөдөлгүүр. Тайлбар толь	MNS ISO 2710:2000
10	Дотоод шаталтын хөдөлгүүр. Хөдөлгүүрийн системийн бүрэлдэхүүн хэсэг, эд ангийн нэр томьёо	MNS ISO 7967-1:2000

11	Автотээврийн хэрэгсэл. Масс. Тайлбар толь ба код	MNS ISO 1176:2001
12	Автотээврийн хэрэгсэл. Өндөр даралтын түлшний насосыг сорих. Хэсэг 1: Динамик нөхцөл.	MNS ISO 4008 1:2001
13	Автотээврийн хэрэгсэл. Өндөр даралтын түлшний хоолойн сорилт. 2-р хэсэг. Статик нөхцөл	MNS ISO 4008 2:2001
14	Автотээврийн хэрэгсэл. Механижсан тээврийн хэрэгслийн оношлогооны систем. Тайлбар толь	MNS ISO 4092:2001
15	Дизель хөдөлгүүр. Өндөр даралтын түлшний насос. Сорилтын өндөр даралтын түлшний хоолой	MNS ISO 4093:2001
16	Автотээврийн хэрэгсэл-Гэрэл ба дохиоллын төхөөрөмж Тайлбар толь	MNS ISO 7227:2001
17	Түлшний багаж хэрэгсэл. Тайлбар толь. 2-р хэсэг. Түлшний форсунк	MNS ISO 7876-2:2001
18	Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. Техникийн шаардлага.	MNS 4410:2002
19	Техникийн найдварт ажиллагааны үндсэн нэр томъёо, тодорхойлолт тайлбар толь	MNS 3831:2003
20	Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд	MNS 4599:2003
21	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага	MNS 5011:2003
22	Жуулчны автотээврийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага	MNS 5231:2003
23	Автомашин угаалгын үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага.	MNS 5347:2003
24	Ачааны машин ба чиргүүлийн хэрэгсэл. Суудлын автомашины чиргүүл САЧ-500 техникийн шаардлага.	MNS 5394:2004
25	Замын тээврийн хэрэгслийн ерөнхий асуудал. Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 4470:2005
26	Автотээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшний нэмэлт төхөөрөмжөөр тоноглох үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5529:2005
27	Хүнсний шингэн тээвэрлэх автоцистерн. Шалгах арга, хэрэгсэл	MNS 5572:2005
28	Зам, тээврийн хэрэгсэл. Автомашин ба чиргүүлийн тоормос-тайлбар толь	MNS ISO 611:2005
29	Машин механизмын бүхээг доторх дуу чимээ түвшинг тодорхойлох	MNS ISO 5128:2005
30	Барилгын ширхгийн ба нурмаг ачаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5645:2006
31	Үр тариа, гурил, будаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5649:2006
32	Өвс, тэжээл тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5647:2006

33	Төмс, хүнсний ногоо тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл.Ерөнхий шаардлага	MNS 5648:2006
34	Түлшний шүршигч төхөөрөмж. Тайлбар толь. 3-р хэсэг. Шүршигчийн бүрдэл	MNS ISO 7876-3:2006
35	Автотээврийн хэрэгсэл болон дотоод шаталтын хөдөлгүүр.Шүүлтүүрийн нэр томьёо. 2-р хэсэг. Шүүлтүүр болон түүний бүрдэл хэсгүүдийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт	MNS ISO 11841-2:2006
36	Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага	MNS 5342:2007
37	Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800 маркийн троллейбус угсрах, ашиглах -Үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага	MNS 5773:2007
38	Улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага	MNS 5831:2007
39	Ачааны терминал. Ангилал ба нийтлэг шаардлага	MNS 5832:2007
40	Автомашинны цахилгаан халаагч /ДН-1/. Техникийн шаардлага	MNS 5878:2008
41	Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.	MNS 5013:2009
42	Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	MNS 5014:2009
43	Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм	MNS 5968:2009
44	Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5025:2010
45	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5044:2010
46	Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага	MNS 6224:2010
47	Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800F загварын дуобус. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6225:2010
48	Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар(VIN) -Агуулга ба бүтэц	MNS ISO 3779:2010
49	Автотээврийн хэрэгслийн -Дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг (WMI)--ийн код	MNS ISO 3780:2010
50	Автотээврийн хэрэгсэл.төрөл, нэр томьёо, тодорхойлолт	MNS ISO 3833:2010
51	Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар(VIN) -байрлал ба бэхэлгээ	MNS ISO 4030:2010
52	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага	MNS 4598:2011
53	Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт	MNS 4601:2011
54	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага	MNS 5012:2011
55	Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх автоцистернийг шалгах арга, хэрэгсэл	MNS 5310 : 2011
56	Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5343:2011

57	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011
58	Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага	MNS 5345:2011
59	Ноос, түүхий эдийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5646:2017
60	Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага.	MNS 6278:2011
61	Автотээврийн үйлчилгээ. Зорчигч тээврийн авто буудал. Ерөнхий шаардлага	MNS 6300:2011
62	Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага	MNS 5879:2012
63	Автотээврийн хэрэгслийн дизель хөдөлгүүрийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшний нэмэлт төхөөрөмжөөр тоноглох үйлчилгээ	MNS 6309:2012
64	Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл. J-800 маркийн автобус. Техникийн шаардлага	MNS 6310:2012
65	Автотээврийн хэрэгсэл. Автомашин, чиргүүлийн хэмжээ. Нэр томъёо, тодорхойлолт	MNS ISO 612:2012
66	Таксийн үйлчилгээ, ерөнхий шаардлага	MNS 5122:2013
67	Тээврийн хэрэгслийн дугуйны хийн даралт хэмжих манометр	MNS OIML R 23 : 2013
68	Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл. Ерөнхий шаардлага	MNS 6438 2014
69	Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага	MNS 6440:2014
70	Резин дугуй, хийлэх хошуу болон дотуур хаймар. Нэр томъёо, тайлбар толь. 1-р хэсэг: Резин дугуй	MNS ISO 3877-1:2014
71	Резин дугуй хийлэх хошуу болон хаймар. Нэр томъёоны тайлбар толь, жагсаалт. 2-р хэсэг: Резин дугуй хийлэх хошуу	MNS ISO 3877-2:2014
72	Автотээврийн хэрэгсэл. Техникийн хяналт болон үйлчилгээний үед ажилласан хийн хорт бодисын агууламжийг хэмжих аргууд	MNS ISO 3929:2014
73	Тээврийн хэрэгслийн ажилласан хий дэх хорт бодисыг хэмжих багаж. Хэмжил зүйн болон техникийн шаардлагууд туршилт явуулах болон хэмжил зүйн хяналт	MNS ISO /PAS 3930:2014
74	Ачааны автомашин, Автобусны резин дугуй болон обуд (метрийн) -1-р хэсэг: Резин дугуй	MNS ISO 4209-1:2014
75	Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтад хөдөлгүүр. Ажилласан хий дэх хорт бодисын агууламжийг хэмжих. 1-р хэсэг: Туршилтын стэнд дээр ажилласан хий дэх тоосонцор болон хий байдалтай хорт бодисыг хэмжих	MNS ISO 8178-1:2014
76	Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтад хөдөлгүүр. Ажилласан хий дэх хорт бодисын агууламжийг хэмжих. 2-р хэсэг: Ажлын нөхцөлд ажилласан хий дэх тоосонцор болон хийн байдалтай хорт бодисыг хэмжих	MNS ISO 8178-2:2014

77	Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтад хөдөлгүүр. Ажилласан хий дэх хорт бодисын агууламжийг хэмжих. 3-р хэсэг: Ажилласан хийн тортогжилтыг тогтонги горимд хэмжих арга ба тодорхойлолт	MNS ISO 8178-3:2014
78	Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтын хөдөлгүүр. Хөдөлгүүрийн чадлыг хэмжих арга, тодорхойлолт. ISO 8178 стандартад заасан ажилласан хийн хорт бодисын агууламжийг хэмжих туршилтын нэмэлт шаардлага	MNS ISO 14396 :2014
79	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 1-р хэсэг: Ерөнхий мэдээлэл болон асуудлыг шийдвэрлэх тохиолдол, тодорхойлолт	MNS ISO 15031-1:2014
80	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 2-р хэсэг: Нэр томъёо тодорхойлолт, товчлол ба товчилсон үгийн тайлбар	MNS ISO 15031-2:2014
81	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 3-р хэсэг: Оношлогооны залгуур болон холбогдох цахилгаан хэлхээ, техникийн тодорхойлолт ба ашиглалт	MNS ISO 15031-3:2014
82	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 4-р хэсэг: Оношлогооны нэмэлт төхөөрөмж	MNS ISO 15031-4:2014
83	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 5-р хэсэг: Ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох үйлчилгээ	MNS ISO 15031-5:2014
84	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 6-р хэсэг: Гэмтэл оношлох код, тодорхойлолт	MNS ISO 15031-6:2014
85	Авто замын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 7-р хэсэг: Холболтын шугамын аюулгүй байдал	MNS ISO 15031-7:2014
86	Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо. Зааврыг ашиглах хэрэгцээ шаардлага	MNS ISO 39001:2014
87	Монгол Улсад үйлдвэрлэсэн авто тээврийн хэрэгсэлд MNS ISO 3779:2010 (VIN) стандартыг хэрэглэх заавар	MNS 6512:2015
88	Тээврийн Чанарын удирдлагын тогтолцоо.Авто зам, төмөр зам, дотоодын усан тээврээр аюултай ачаа тээвэрлэхэд Чанарын удирдлагын тогтолцооны	MNS EN 12798 : 2015
89	Тээвэр. Логистик ба үйлчилгээ. Ачаа тээвэрлэлтийн гинжин хэлхээ. Карго тээврийн үйлчилгээ үзүүлэх дүрэм	MNS EN 13876: 2015
90	Ачаа тээврийн үйлчилгээ. Ачаа тээврийн сүлжээний байгаль орчинд нөлөөлөх талаарх мэдүүлэг ба тайлан	MNS CEN/TR 14310: 2015

91	Дотоод шаталтын хөдөлгүүр болон компрессорын агаарын шүүлтүүр. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг туршилтаар шалгах	MNS ISO 5011:2015
92	Авто замын тээврийн хэрэгсэл. Их гэрлийн цацрагийн тусгалыг хэмжих төхөөрөмж	MNS ISO 10604:2015
93	Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо, тодорхойлолт	MNS 0639:2016
94	Тээврийн хэрэгсэлд ашиглах тусгай дуут болон гэрлэн дохио. Ерөнхий шаардлага	MNS 4979:2016
95	Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага	MNS 5537 :2016
96	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага	MNS 6584 : 2016
97	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага	MNS 6585 : 2016
98	Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага	MNS 6592:2016
99	Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 6593:2016
100	Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрлэл. Ерөнхий шаардлага	MNS 6594:2016
101	Автотээврийн салбарын ажилчдын ажил мэргэжлийн стандарт	MNS 6595:2016
102	Мотоцикл болон мопедийн жолооч болон зорчигчийн хамгаалах малгай болон шилэн нүүрвч. Ерөнхий шаардлага	MNS 6629 : 2016
103	Хийлдэг дугуйн обуд ба резин дугуй. Тайлбар толь, тэмдэг ба тэмдэглэгээ	MNS ISO 3911:2016
104	Мотоциклын резин дугуй ба обуд (Кодын тэмдэглэгээтэй цуврал). 2-р хэсэг: Резин дугуйн даацын зэрэглэл	MNS ISO 4249-2:2016
105	Хүнд машин, механизмын резин дугуй болон обуд 1-р хэсэг: Дугуйн тэмдэглэгээ болон хэмжээс	MNS ISO 4250-1:2016
106	Мотоциклын резин дугуй ба обуд (метрийн цуврал). 2-р хэсэг:Резин дугуйны хэмжээ ба даац	MNS ISO 5751-2:2016
107	Автотээврийн хэрэгсэл. Хоёр дугуйтай мопед болон мотоциклын хэмжээс. Нэр томьёо тодорхойлолт	MNS ISO 6725:2016
108	Автотээврийн хэрэгсэл. Зам, тээврийн ослын шинжилгээ. 1-р хэсэг: Нэр томьёо, тайлбар толь	MNS ISO 12353-1:2016
109	Автотээврийн хэрэгсэл. Зам, тээврийн ослын шинжилгээ. 2-р хэсэг: Ослын нөлөөллийн ноцтой байдлын хэмжүүрийг ашиглах заавар	MNS ISO 12353-2:2016
110	Автотээврийн хэрэгсэл. Зам, тээврийн ослын шинжилгээ. 3-р хэсэг:Ослын нөлөөллийн ноцтой байдлыг тодорхойлох үүднээс мөргөх үеийн цохилтын импульсийн бичигдсэн өгөгдөл, мэдээллийг тайлж унших заавар	MNS ISO/TR 12353-3:2016
111	Автозамын тээврийн хэрэгсэл-Хүүхдийн хамгаалалтын системийн төхөөрөмж, хэрэгслүүд болон тээврийн хэрэгслийн дотор бэхэлгээ-1 дүгээр хэсэг: Суудал болон түшлэгний уулзвар дээр байрлуулах бэхэлгээ болон төхөөрөмж.	MNS ISO 13216-1: 2016

112	Авто тээврийн хэрэгсэл-Хүүхдийн хамгаалах системд зориулсан Тээврийн хэрэгсэл дэх бэхэлгээ ба холбоос-2 дугаар хэсэг: Дээд уяаны бэхэлгээ ба холбоос.	MNS ISO 13216-2: 2016
113	Авто тээврийн хэрэгсэл-Тээврийн хэрэгсэл дэх бэхэлгээ ба хүүхдийн хамгаалалтын системийн бэхэлгээний холбоос-3 дугаар хэсэг: Хүүхдийн хамгаалах хэмжээний ангилал ба тээврийн хэрэгсэл дэх зай.	MNS ISO 13216-3: 2016
114	Автотээврийн хэрэгсэл. Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын байранд тавигдах эргономикийн шаардлага. 1-р хэсэг: Ерөнхий тодорхойлолт, үндсэн шаардлага.	MNS ISO 16121-1:2016
115	Автотээврийн хэрэгсэл. Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын байранд тавигдах эргономикийн шаардлага. 4-р хэсэг: Жолоочийн бүхээгийн орчин	MNS ISO 16121-4:2016
116	Бүх төрлийн замд ашиглах резин дугуй ба обуд. 5 градусын налуутай обудад угсрах резин дугуй тэмдэг. Тодорхойлолт, хэмжээс, тэмдэглэгээ болон даацын зэрэглэл	MNS ISO 29802:2016
117	Тээврийн хэрэгслийн хурд хэмжих радар төхөөрөмж	MNS OIML R91:2016
118	Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага	MNS4410-2:2017
119	Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4978:2017
120	Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ	MNS 5346:2017
121	Автомашин хөдөлгүүрийг стэнд дээр турших арга	MNS 6664:2017
122	Дотоод шаталтын хөдөлгүүр. Хөдөлгүүрийн чадлыг хэмжих арга, тодорхойлолт. Ерөнхий шаардлага	MNS ISO15550:2017

1.2. АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тээврийн бусад төрлүүдтэй харьцуулахад өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэд бүтэц сул хөгжсөн манай улсын хувьд автотээврийн хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж, тээвэрлэлтийн үйл ажиллагааны гүйцэтгэлээс харахад тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн нийт зорчигч тээврийн 98 хувийг, ачаа тээврийн 60 гаруй хувийг автотээврийн хэрэгслээр тээвэрлэж байна.

Автотээврээр 2017 оны жилийн эцсийн байдлаар 31 сая тонн ачаа, давхардсан тоогоор 212,2 сая зорчигч тээвэрлэж өмнөх оныхоос тээсэн ачаа 11 сая тонн буюу 35.2 хувь, зорчигчдын тоо 48.5 сая зорчигч буюу 22.8 хувиар буурсан байна. Автотээврийн орлого өмнөх оныхоос 12,9 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар өссөн байна.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, төрөөс улсын өмчийг хувьчлах бодлогыг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний дөрвөн компаниас бусад бүх автотээврийн байгууллагууд хувьчлагдан улс, хот хооронд, аймаг, хотын дотор болон хот орчмын ачаа, зорчигч тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотой үйлчилгээг хувь хүмүүс, аж ахуйн нэгж гүйцэтгэж байна.

Зах зээл өргөжихийн хирээр автомашины тоо сүүлийн жилүүдэд огцом өсч, 5 иргэн тутмын нэг нь автомашин жолоодох эрхийн үнэмлэхтэй болсон байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 900,1 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 58,9 хувь нь Улаанбаатар хотод 41,1 хувь орон нутагт бүртгэлтэй байна. Тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлаас харахад 10-аас дээш насжилттай тээврийн хэрэгсэл 82 хувийг эзэлж байна. Баруун гар талдаа хүрдтэй тээврийн хэрэгсэл нийт тээврийн хэрэгслийн 58 хувийг эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслээс 16 хувь буюу 131573 нь хосолсон, 2,2 хувь буюу 18299 нь хийн, 0,01 хувь буюу 90 нь цахилгаан хөдөлгүүртэй байна.

**Хүснэгт 4. Тээврийн хэрэгслийн нийт тоо ба техникийн хяналтын үзлэгт
хамрагдсан тээврийн хэрэгслийн судалгаа**

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017
1	Тээврийн хэрэгслийн нийт тоо	487217	504423	620661	674869	720278	766079	900125
2	Тех.хян.үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо	312542	345473	384864	437677	482049	499152	551537
3	Хувиар	64	68.4	62	64.8	66.9	65.1	61.2

Улсын хэмжээнд 2017 онд 551,5 мянган тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 82 хувийг иргэд, 14,6 хувийг компани, аж ахуйн нэгж, байгууллагууд, 1,9 хувийг төрийн болон орон нутгийн өмч, 1 хувийг төрийн бус байгууллага, 0,4 хувийг гадаадын иргэд, 0,1 хувийг дипломат болон олон улсын байгууллагууд эзэмшиж байна.

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан сүүлийн 7 жилийн судалгаанаас харахад Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 65 хувь хамрагдаж байна. Энэхүү үзүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч ашиглагддаггүй тээврийн хэрэгслийн судалгааг гарган, шинэчилсэн бүртгэлийг хийхээр ЗТХ яамны зүгээс бүртгэлийн программыг шинэчлэх, эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байна.

Авто үйлчилгээний байгууллага: Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Автотээврийн тухай хуулийн 3.1.18-д “авто үйлчилгээний байгууллага” гэж автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчид үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг ойлгоно гэж заасан байна.

Хуулийн 19² дугаар зүйлд зааснаар авто үйлчилгээний байгууллага нь тухайн үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах, тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг хэмжилзүйн мэргэжлийн байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах шаардлагатай гэж заасан.

Түүнчлэн авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэж заасны дагуу Зам тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар “Авто

үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам”-ууд тус тус батлагдан мөрдөгдөж байна.

Авто үйлчилгээний байгууллага нь өөрийн ангилалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, тухайн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчдийн талаарх судалгааг тогтоосон журмын дагуу автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх үүргийг хууль болон дээр дурьдсан журмаар хүлээдэг.

Зам, тээврийн хөгжлийн яам болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2016 онд авто үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хүний амь нас, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэхийг тодорхойлж, авто үйлчилгээний мэдээллийн сан болох “Үйлчилгээ-Оношлогоо-Хяналтын нэгдсэн систем”-ийг баяжуулах, эрсдэл бууруулах арга хэмжээ авахаар тандан судалгаа хийжээ.

Судалгаанд нийт 147 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна. Аймгуудаас ирүүлсэн мэдээллээр хөдөө орон нутагт 1256, нийслэлд 966 авто үйлчилгээний байгууллага байгаагаас 50 орчим хувь нь авто засварын газар, дугуй засварын газар байдаг байна.

Эндээс үзэхэд хөдөлгөөний аюулгүй байдалд шууд нөлөөлөх тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд тавих хяналт, үйлчилгээний чанарын баталгааг хангуулах шаардлага зайлшгүй байна.

Тандан судалгаагаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчил нь “Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага” MNS5020:2010 стандартын дагуу техникийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, зааварчилгааг боловсруулж мөрдөж ажилладаггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл өмсч хэвшээгүй, ажилтнууд мэргэжлийн бус, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагддаггүй, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу үйлчилгээ эрхэлж буй иргэд, байгууллагууд нь хаягдал тос болон хогыг тогтмол цэвэрлэх арга хэмжээ авдаггүй зэрэг нийтлэг зөрчил дутагдалтай байгааг дүгнэсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд авто үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй байх, үйл ажиллагаандаа заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байх, хэрэглэгчдэд чанар, аюулгүй байдлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, эдгээртэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгийн баруун гар талаар явуулна” гэж заасан.

Монгол Улсад ашиглагдах автотээврийн хэрэгсэл, авто зам, замын байгууламжуудын инженерийн шийдэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлтийн тооцоог болон замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой хууль, дүрэм, журам, стандартуудыг боловсруулахдаа зүүн талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн үзүүлэлтээр тооцож боловсруулагдсан байдаг.

Дэлхийн улс орнуудад замын хөдөлгөөнийг зорчих хэсгийн баруун эсхүл зүүн гар талаар явуулах эсэхээ дотоодын хууль тогтоомжоороо тогтоон түүндээ нийцүүлэн автомашины жолооны хүрдний байрлалыг хуульчлан тодорхой зааж өгсөн байдаг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад замын үзэгдэх орчин чухал үүрэгтэй бөгөөд манай орны хувьд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслээр гүйцэж түрүүлэх, тойрон гарах үйлдэл хийхэд харах талбайг 20-70 градусаар багасгахаас гадна баруун гар тийш эргэх үед жолооч талын баганад явган зорчигч харагдахгүй байдлаас үүдсэн осол гарахад нөлөөлдөг.

2016 онд зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо 488 байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нас барсан хүний тоо 59-өөр өссөн үзүүлэлттэй байна. 2017 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар Монгол Улсад 892 665 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 809 023 буюу 90.6 хувь нь автомашин байна. Нийт тээврийн хэрэгслийн 49.9 хувийг баруун талдаа жолооны хүрдтэй автомашин эзэлж байна.

Монгол Улсад 2009-2015 онд гарсан зам, тээврийн ослын судалгаанаас харахад 2009 онд 6225 зам тээврийн осол гарснаас 2977 нь буюу 47,9 хувь нь, 2010 онд 6351-ээс 3188 нь буюу 50,2 хувь нь, 2011 онд 15909-өөс 8210 нь буюу 51,6 хувь нь, 2012 онд 12920-иос 7653 нь буюу 59,2 хувь, 2013 онд 14662-оос 7296 нь буюу 49,8 хувь, 2014 онд 11630-аас 6862 нь буюу 59 хувь, 2015 онд 41064-өөс 26445 нь буюу 64,4 хувь нь нь баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл осолд орсон байна.

Олон улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдүгээрт зам тээврийн осол гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хоёрдугаарт зам тээврийн ослоос үүдэн гарах хохирлыг багасгах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах боломжийг эрэлхийлэх гэсэн хоёр төрлөөр зохицуулагдаж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдлыг хангах нь хамгийн чухлаар тавигдаж байна.

Тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, дахин боловсруулалтын үйл ажиллагаа, стандартын шаардлага хангуулахад тавих хяналт:

Монгол Улсад автотээврийн хэрэгслийг шинээр угсарч, үйлдвэрлэж эхэлж байгаа хэдий ч машин үйлдвэрлэлийн эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Одоогоор машин үйлдвэрлэлийн салбарт дараах үндэсний стандартууд мөрдөгдөж байна.

➤ MNS5773:2007 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800 маркийн тролейбус угсрах, ашиглах. Үндсэн параметрууд ба техникийн ерөнхий шаардлага;

➤ MNS6225:2010 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800F маркийн доубус. Техникийн ерөнхий шаардлага;

➤ MNS6310:2012 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл JEA-800 маркийн автобус. Техникийн ерөнхий шаардлага;

➤ MNS6224:2010 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага;

➤ MNS6311:2012 Хөдөө аж ахуйн машин техник. МОН-1000-90 загварын будаа ачих машин. Техникийн ерөнхий шаардлага.

Дээрх стандартын дагуу Монгол Улсад 2006 оноос хойш нийт 100 тээврийн хэрэгсэл угсарч үйлдвэрлэсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Автотээврийн тухай хуулиар зохицуулалт байхгүй, харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.15-д төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг үйлдвэрлэл, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгохоор заасан байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас нийт

9 аж ахуйн нэгжид төмөрлөг, машин үйлдвэрлэлийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Цаашид Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, агрегат, эд анги нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй байх, үйлдвэрлэсэн, угсарсан автотээврийн хэрэгсэл, агрегат, эд анги нь үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагыг тогтоох асуудлыг зохицуулах, энэ талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хуурамч сэлбэг хэрэгслийг улсын хилээр оруулах, засвар үйлчилгээг стандартын бус нөхцөлд явуулж буй зөрчлийг таслан зогсоох зорилгоор стандартын шаардлага хангуулах, бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулах шаардлагатай.

4.1.3. “техникийн зохицуулалт” гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын зорилго

5.1. Техникийн зохицуулалтын зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

5.2. Техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөнө.

5.3. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газар, хэрэгжилтийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага тус тус хариуцна.

6 дугаар зүйл. Техникийн зохицуулалтыг боловсруулах, батлах, мэдээлэх

6.1. Техникийн зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, энэ хуулийн 6.4-т заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална.

6.2. Техникийн зохицуулалт боловсруулах зааврыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

6.3. Шаардлагатай тохиолдолд техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журмыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.4. Техникийн зохицуулалтын төсөл нь энэ хуулийн 5.1-д заасан зорилго, 6.2-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.

6.5. Монгол Улсаас гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтын төслийг батлагдахаас гурваас доошгүй сарын өмнө стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлнэ.

6.6. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Хавсралт

АВСТРАЛИ УЛСЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СТАНДАРТ

ГАРЧИГ

Бүлэг-1. Удиртгал

1-р хэсэг. Ерөнхий

1. Хуулийн хүрээндэх нэршил
2. Авто тээврийн хэрэгслийн стандартыг хэрэглэх хүрээ

2-р хэсэг. Авто тээврийн хэрэгслийн стандартын тогтолцоо

3. Тодорхойлолт
4. Диаграм
5. Анхаарамж
6. Жишээ

Бүлэг-2. Авто тээврийн хэрэгслийн стандартыг хэрэглэх цар хүрээ

7. Авто тээврийн хэрэгсэл ба өөрөө явагч машин механизм .
8. Авто зам гэж юу вэ
9. Авто замын хүрээний бүс
10. Авто тээврийн хэрэгсэлийн стандартад хамаарахгүй авто тээврийн хэрэгсэл
11. Стандартад багтаагүй машин механизм ба тэдгээрийн бусад хуулийн зохицуулалт
12. Стандартад багтаагүй машин механизм ба Австралийн хийцийн шаардлагад нийцээгүй
13. Стандартад багтаагүй машин механизм ба дүрэм журамд багтаагүй

Бүлэг-3. Австралийн Стандарт, дизайн \Australian design rules ADR\

1-р хэсэг. Тайлбар

14. ADR гэж юу вэ
15. Үндэсний стандарт гэж юу вэ
16. Үндэсний стандартуудын тодорхойлолт
17. ADR –ийн хоёрдогч хувилбар гэж юу вэ
18. ADR –ийн гуравдагч хувилбар гэж юу вэ

2-р хэсэг. ADR стандартуудын зохицол

19. ADR хоёрдогч хувилбарын зохицол
20. ADR гуравдагч хувилбарын зохицол
21. Тусгай заалтын зохицуулалт–бусад өөрөө явагч машин механизм
22. Тусгай заалтын зохицуулалт-Замаар өөрөө явагч моторт машины стандарт
23. Хэсэгчилсэн тусгай заалтын зохицуулалт-Хувийн зориулалттай импортын машин

Бүлэг-4. Гадаад улсын стандартыг ашиглах

24. Гадаад улс орны стандарт хэрэглэх гэж юу вэ
25. Гадаад улсын стандартын тодорхойлолт гаргах
26. Гадаад улсын стандартын тусгай заалтын ,хавсралтын зохицуулалт

Бүлэг-5. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

1-р хэсэг. Бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл

27. Жолоодлого
28. Эргэлтийн чадвар
29. Туулах чадвар урагшаа зүтгэх ба ухрах
30. Огцом хүч гаргалт
31. Хянах самбар ба заах хэрэгсэл
32. Суудал
33. Шаврын хаалт ,үсрэлтийн хамгаалалт
34. Дуут дохио,дохиолол
35. Арын толь
36. Арын толь-гадаргуу
37. Нэмэлт толь
38. Automatic transmission автомат дамжуулга
39. Дизель хөдөлгүүр
40. Хөдөлгүүрийн бүрээс түүний хамгаалах тоноглол
41. Цахилгаан утас холболт ба суурилуулалт
42. Телевизор хүлээн авагч ба мэдээлэх самбарын тоноглол
43. Салхины шил ба хажуугийн шил
44. Цонхны шилний өнгө тохируулалт
45. Салхины шил арчих ба угаах тоноглол
46. Дугуй ба хамер
47. Хийн дугуй ерөнхий
48. Хийн дугуй – араг бие /обудь/
49. Хийн дугуй –хэмжээ ба даац
50. Дугуй –дефект
51. Тээврийн хэрэгслийн нийт жин
52. Дугуй – Үйлдвэрлэлийн зэрэглэл
53. Дахин боловсруулалт
54. Дугуйн хээ

2-р хэсэг. Моторт дугуйн нэмэлт шаардлага

55. Залуурын механизм ба жолоо
56. Хөлийн гишгүүр,тавиур
57. Гинж хамгаалагч

Бүлэг-6. Авто тээврийн хэрэгсэл марклалт

58. Авто тээврийн хэрэгсэл ба хөдөлгүүрийн бүртгэлийн дугаар
59. Тээврийн хэрэгслийн цагаан ба мөнгөлөг тууз
60. 22м –ээс илүү уртад хэрэглэх анхааруулах тэмдгийн иж бүрдэл
61. Анхааруулах тэмдэгүүд бусад авто тээврийн хэрэгсэлд ашигладаггүй
62. Анхааруулах тэмдэгийн шаардлага
63. Зүүн талтай машины жолоодлогийн дохио

Бүлэг-7. Авто тээврийн хэрэгслийн тохиргоо ба хэмжээсүүд

1-р хэсэг. Тэнхлэг

- 64. Тэнхлэг тохиргоо
- 65. Гол хоорондын ба тэнхлэг тохиргоо

2-р хэсэг. Хэмжээсүүд

- 66. Өргөн
- 67. Дан моторт авто тээврийн хэрэгслийн урт
- 68. Дан чиргүүлийн урт
- 69. Уртын хэмжээсүүд
- 70. Арын дэгээ
- 71. Чиргүүлийн гол хөтлүүрийн урт
- 72. Өндөр
- 73. Газраас дээших өндөржилт

Бүлэг-8. Гэрэл ба тусгах толь

1-р хэсэг. Гэрлийн ерөнхий шаардлага

- 74. Зөвхөн шөнийн гэрэлтүүлгийн үндсэн шаардлага
- 75. Гялбааны сэргийлэх
- 76. Хос гэрэл

2-р хэсэг. Урд гэрэл

- 77. Авто тээврийн хэрэгсэлийн урд гэрэл
- 78. Хэрхэн яаж урд гэрлийг суурилуулах вэ
- 79. Дан гэрлийг суурилуулах
- 80. Нэмэлт урд гэрлийг суурлуулах
- 81. Урд гэрлийн хүчин чадал
- 82. Урд гэрлийн тусгалын үр ашигтай хүрээ
- 83. Урд гэрлийн холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлэх

3-р хэсэг. Оврын гэрэл

- 84. Оврын гэрэл

4-р хэсэг. Өдрийн гэрэл

- 85. Өдрийн гэрэл

5-р хэсэг. Хойд гэрэл

- 86. Хойд гэрэл ерөнхий
- 87. Хойд гэрлийг суурьлуулах үндсэн загвар
- 88. Хойд гэрлийн чадал
- 89. Хойд гэрлийн цахилгаан утас

6-р хэсэг. Машины дугаарын гэрэл

- 90. Машины дугаарын гэрэл

7-р хэсэг. Нэмэлт гэрэл

- 91. Урд нэмэлт гэрлүүд
- 92. Кабины гаднах гэрэл
- 93. Арын нэмэлт гэрэл

8-р хэсэг. Хажуугын гэрэл

- 94. Тээврийн хэрэгслийн хажуугын гэрэл
- 95. Хажуугын гэрлийн байрлал
- 96. Хажуугын гэрлийн чадал
- 97. Хажуугын гэрэл ба арын нэмэлт гэрэл

9-р хэсэг. Тоормосны гэрэл

- 98. Тоормосны гэрэл суурилуулах
- 99. Тоормосны гэрлийн ажиллагаа ба чадал

10-р хэсэг. Ухрах гэрэл

- 100. Ухрах гэрэл

11-р хэсэг. Чиглэл заагч гэрэл

- 101. Тээврийн хэрэгслийн чиглэл заагч гэрэл
- 102. Чиргүүлийн чиглэл заагч гэрэл
- 103. Чиглэл заагч гэрлийн байрлал
- 104. Чиглэл заагч гэрлийн ажиллагаа ба үзэгдэх хүрээ

12-р хэсэг. Манангийн гэрэл

- 105. Урд манангийн гэрэл
- 106. Хойд манангийн гэрэл

13-р хэсэг. Дотоод гэрэл

- 107. Дотоод гэрэл

14-р хэсэг. Ерөнхий тусгах толь

- 108. Тусгах толины ерөнхий шаардлагууд

15-р хэсэг. Хойд тусгах толь

- 109. Хойд тусгах толь

16-р хэсэг. Хажуу талын тусгах толь

- 110. Role-type чиргүүлд зайлшгүй байх хажуу талын тусгах толь
- 111. Зайлшгүй биш хажуу талын тусгах толь

17-р хэсэг. Урд тосгох толь

- 112. Чиргүүлд зайлшгүй байх урд тусгах толь
- 113. Зайлшгүй биш урд тусгах толь

18-р хэсэг. Дохионы гэрэл ба хүүхэд тээвэрлэж яваа автобусны тэмдэгүүд

- 114. Ашиглах хүрээ

- 115. Дохионы гэрэл болон тэмдэгийг суурилуулах
- 116. Дохионы гэрлийн ажиллагаа ба хүчин чадал
- 117. Дохионы гэрлийн шаардлага

19-р хэсэг. Бусад гэрэл, тусгах толь, арын таних тэмдэг ба дохио

- 118. Бусад гэрэл болон тусгах толь
- 119. Арын таних тэмдэг
- 120. Дохионы хэрэгслүүд
- 121. Механик дохионы хэрэгсэл
- 122. Дохионы гэрэл

20-р хэсэг. Гэрэл болон тусгах толь байх шаардлагагүй тээврийн хэрэгсэл

- 123. Өдрийн цагаар ашигладаг тодорхой тээврийн хэрэгсэл
- 124. Цуглуулга, үзэсгэлэнгийн зориулалтаар ашигладаг тээврийн хэрэгсэл

Бүлэг-9. Тоормосны тогтолцоо

1-р хэсэг. Бүх тээврийн хэрэгслийн тоормосны шаардлага

- 125. Тоормосны системийн сэлбэг
- 126. Элэгдэлээс хамгаалах арга хэмжээ авах
- 127. Тоормосны агаар болон вакуумаар хангах
- 128. Тоормосны системийн хүчин чадал

2-р хэсэг. Автомашины тоормосны систем

- 129. Автомашины тоормосны систем ямар байх ёстой вэ
- 130. Автомашины тоормосны ажиллагаа
- 131. Автомашины агаарын ба вакуум тоормос

3-р хэсэг. Чиргүүлийн тоормосны систем

- 132. Чиргүүл ямар тоормостой байх ёстой вэ
- 133. Чиргүүлийн тоормосны ажиллагаа
- 134. Чиргүүлийн агаарын болон вакуум тоормос

4-р хэсэг. Урт автомашины цуваа болон В-хослолд зориулсан нэмэлт тоормосны шаардлага

- 135. Тодорхой автомашины цувааны ашиглалт
- 136. В- хослол –н чирэгчийн тоормосын системийн хийц
- 137. Автовагоны чирэгч толгойн тоормосны систем
- 138. Автовагон болон В-double дах чиргүүлийн тоормосны системийн хийц
- 139. Автовагон эсвэл В-double-н автомашины агаарын тоормос
- 140. Автовагон эсвэл В-double-н агаарын тоормос: least favoured chamber
- 141. Чё
- 142. Автовагон эсвэл В-double-н тоормосыг агаараар хангах
- 143. Тоормосны шугамын баривч
- 144. Зогсоолын тоормосыг зэрэг ашиглах
- 145. Нөөцлүүрийн багтаамж

Бүлэг-10. Машинаас ялгарах утааг хянах

1-р хэсэг. Хөдөлгүүрийн тэвшний хий болон машинаас ялгарах нүдэнд үзэгдэх утаа

- 146. Хөдөлгүүрийн тэвшний хий
- 147. Нүдэнд үзэгдэх утаа

2-р хэсэг. Яндангийн систем

- 148. Яндангийн систем

3-р хэсэг. Чимээ гаргалт

- 149. Яндангийн системийн дуу намжаах төхөөрөмж
- 150. Тогтмол чимээний түвшин – Хөнгөн тэрэгний төрлийн тээврийн хэрэгсэл, мотоцикл мөн гурван дугуйт
- 151. Тогтмол чимээний түвшин – Очин асаалгатай хөдөлгүүртэй бусад тээврийн хэрэгсэл
- 152. Тогтмол чимээний түвшин – дизель хөдөлгүүртэй бусад тээврийн хэрэгсэл
- 153. Тогтмол чимээний түвшиний хэмжилт

Бүлэг-11. LPG түлшний систем

- 154. LPG моторт тээврийн хэрэгсэл

Бүлэг-12. Автозамын хурдны дээд хязгаар

- 155. Хурдны хязгаар
- 156. Хурдны хязгаарын хөнгөлөлт

Бүлэг-13. Тээврийн хэрэгслүүдийн хоорондох механик холболтууд

1-р Хэсэг Бүх төрлийн тээврийн хэрэгслийн холбуур

- 157. Холбуурын ерөнхий шаардлагууд
- 158. Хатуу холбоос

2-р хэсэг Урт Автовагон болон В –хослол-д тавигдах нэмэлт холбуурын шаардлага

- 159. Автомашины цувааны хэсгийн ашиглалт
- 160. Автовагон болон В-Doubles-н холбуур
- 161. Автовагон болон В-Doubles-д битүү чиргүүлийн холбуур сонгох
- 162. Битүү чиргүүлийн холбуурын D-үнэлгээ
- 163. Автовагон болон В-Doubles-н битүү чиргүүлийн холбуурны угсралт
- 164. Автовагон болон В-Doubles-н битүү чиргүүл болон эргэлтийн тойргийн тэмдэглэгээ
- 165. Автовагон болон В-Doubles-н дамрын сонголт
- 166. Автовагон болон В-Doubles-н дамрын бэхэлгээ
- 167. Автовагон болон В-Doubles-н дамрын тэмдэглэгээ
- 168. Автомашины цуваанд холбуур болон дамрын нүдийг сонгох
- 169. Автомашины цуваанд холбуур болон дамрын нүдийг бэхлэх
- 170. Автомашины цувааны холбуур болон дамрын нүдний тэмдэглэгээ
- 171. Автомашины цувааны чирэх холбуурын Overhang

Бүлэг-14. Бусад зүйлс

- 172. Тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж
- 173. Сэргээн зассан тээврийн хэрэгсэл
- 174. Татгалзаж болох тэнхлэг
- 175. Зэрэгцээ шугам хоорондын зайг хэмжих
- 176. ADRs 2 дах хэвлэлийн тодорхой тайлбар

БҮЛЭГ- 5. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

Авто тээврийн хэрэгсэл нь аюулгүй найдвартай ажиллагааны түвшин өндөр ,техникийн хувьд шинэлэг хийц загвар өнгө үзэмж сайтай ,эрчим хүч ба бусад ашиглалтын

материал бага зарцуулдаг бусад авто тээврийн хэрэгсэлтэй зохицож хөдөлгөөнд оролцох боломж бүхий байна.

Энэхүү стандарт журмыг авто тээврийн хэрэгслийг жолоодох ,жолоодлогийн удирдлага ,зорчигчын ба замаар зорчигч бусад объектын аюулгүй байдал ба бусад аюулгүй ажиллагааны дүрэм журмд нийцүүлэн үйлдэв

1-р Хэсэг Бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл

27. Жолоодлого

1. Тээврийн хэрэгслийн бүрэн жингийн хэмжээ 4.5 тонн –оос их бол баруун талдаа жолоодлогийн хүрдтэй байна.
2. Тээврийн хэрэгслийн бүрэн жингийн хэмжээ 4.5 тонн-оос бага тээврийн хэрэгсэл нь хэрвээ баруун талдаа бол :
 - 30 жилээс илүү насжилттай
 - Хуулийн заалтын дагуу баруун талдаа жолоодлоготой бол
3. Моторт авто тээврийн хэрэгсэл нь хэрвээ төвдөө хамгийн багадаа ганц жолоодлогийн удирдлагатай бол жолоодлогийн удирдлага нь баруун талд эсвэл баруун шугам дээр
4. Моторт авто тээврийн хэрэгслийн жолоодлогийн механизм нь найдвартай үр ашигтай байх үндсэн зарчим нь хүч дамжуулах систем зөвхөн механик аргаар хийгдсэн байхад сая биелэнэ
5. Жолоодлогийн системийн механик бус эд ангийн эвдрэл гэмтэл нь жолоодлогийн системийн үр ашигтай удирдаж зохицуулах боломжгүй байдалд хүргэнэ.
6. Энэхүү журамд заагдаагүй ачаа ба хүн тээвэрлэх хэрэгсэл, машин механизм өөрөө явагч хэрэгсэлд хамаарахгүй

28. Эргэлтийн чадвар

1. Моторт авто тээврийн хэрэгсэл нь 25м-н диаметртэй тойрог дотор эргэлт хийх чадвартай байх дугуйны гадаад ирмэгээс тооцож хэмждэг байна.
2. Аливаа тээврийн хэрэгсэл нь 28-н /1/-р журмыг хангасан байх ба баруун ба зүүн тийш эргэсэн ч хамаарахгүйгээр дээрх нөхцөлийг хангаж байна.

29. Туулах чадвар урагшаа зүтгэх ба ухрах

Ачаагүй өөрийн жин 450 кг аас их авто тээврийн хэрэгсэл нь жолоочын хэвийн байрлалд урагшаа ба хойшоо хоёр чиглэлд чөлөөтэй хөдлөх боломж бүхий байна

30. Овроос илүү гарсан хэсэг

1. Авто тээврийн хэрэгсэлийн үндсэн биеэс илүү гарсан хэсгүүд нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн ,тээврийн хэрэгсэлтэй ажиллах хүний ажиллагаанд аль болох бага саад учруулхаар хийгдсэн байна
2. 30-н /1/-г баримтлахгүйгээр тээврийн хэрэгсэлд илүү гарсан деталь байрлуулах бол /толь,антен,гэх мэт /
 1. Авто тээврийн хэрэгсэл 1965 оноос өмнөх зураг төслөөр хийгдсэн ба тухайн объект нь тээврийн хэрэгслийн зураг төслийн бүрэлдхүүн болон хийгдсэн бол

2. Авто тээврийн хэрэгсэл нь 1965 оноос өмнөх зураг төслөөр хийгдсэн ба хуулийн тодорхой заалтын дагуу нэмэлт бүрэлдхүүн хэсэг зураг төсөлд тусгагдан хийгдсэн бол

31. Хянах самбар ба заах хэрэгсэл

Моторт авто тээврийн хэрэгсэл нь :

- a) Авто тээврийн хэрэгсэл нь жолоодох үед урдах зам ба эргэн тойрны орчинг чөлөөтэй харж болохуйцаар хийгдсэн байж тээврийн хэрэгслийн ажиллагаа ба техникийн эвдрэл гэмтэл ба бусад шаардлагатай мэдээлэлийг тусгай заах хэрэгслээр жолоочид мэдээлэх боломжтой байна.
- b) Хяналтын самбар ба жолоочын байрлал нь дээр дурдсан нөхцөлийг хангаж буй тээврийн хэрэгсэл нь хөдөлгөөнд аюулгүй оролцох боломжтой

32. Суудал

Авто тээврийн хэрэгсэл нь жолооч ба зорчигчын ая тухыг хангасан тохиромжтой,эргономикийн шаардлага хангасан,машины үндсэн биед бат бэх суурилагдсан суудал бүхий байна.

33. Шаврын хаалт ба үсрэлтийн хамгаалалт

- 1) Авто тээврийн хэрэгсэлд бат бэх найдвартай суурилагдсан байна.
 - a) Дан ба хос дугуйнууд нь бүгд эргэлтийн чиглэлийн дагуу шаврийн хаалттай байна.
 - b) Хос тэнхлэг ба нэгж тэнхлэг бүр дэх В хос – үсрэлтээс хамгаалах ханийг Британи Стандарт AU 200-1984 Бүлэг 1,2 –г дэх Хүнд авто тээврийн хэрэгслийн шаврын хаалт ,үсрэлтээс хамгаалах деталь хэсэгт зааснаар тус тус суурилуулсан байна.
- 2) 33 –н /1/-н 'а'-г хангаагүй аливаа тээврийн хэрэгсэл нь :

- a) Тухайн авто тээврийн хэрэгслийн үндсэн хэрэглээ ба ашиглалтад шаврын хаалт нь үл нийцдэг эсвэл онц шаардлагагүй
- b) Тээврийн хэрэгслийн үндсэн их биеийн нэг хэсэг нь үсрэлтээс хамгаалах шаврын хаалтын үүрэг гүйцэтгэж байгаа бол
Жишээлбэл 33-н /2/-р заалтын "а"-д хамрагдах тээврийн хэрэгсэл нь :
 - 1. Мод тээвэрлэх зориулалтай
 - 2. Ихэнх зам барилгын машин механизм
 - 3. Зарим хөдөө аж ахуйн машин механизм
- 3) Авто тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5 тонн-оос их заавал шаврын хаалт бүхий байх ба тээврийн хэрэгсэл хөдлөх үед дугуй нь өөрийн байрлалаас дараах урагшаа хөдлөгөөн хийх үед:
 - a) Дугуйн хөдөлгөөн нь ойр орчим байгаа хүнд аль болох бага аюул осол учруулахуйц
 - b) Арын дугуй нь :
 - i. Дан ба хос дугуйны өргөний хэмжээг бүрэн бүрсэн байхуйцаар
 - ii. Арын дугуйны шаврын хаалтны доод ирмэгээс газрын гадаргийн түвшин хүртэлх өндөр хамгийн бага хэсгээс арын тэнхлэгийн төв хүртэлх зайн гуравны нэгтэй тэнцэхүйц хэмжээтэй байна.
- 4) Шаврын хаалтын өндөржилт нь мөн дараах хэмжээнд хүрч болно
 - a) Газрын түвшингээс дээш 230мм
 - b) Хэрвээ тухайн авто тээврийн хэрэгсэл нь авто замаар явдаггүй бол газрын түвшингээс дээш 300мм
- 5) Гадагшаа илүү гарсан арын шаврын хаалт нь авто тээврийн хэрэгслийн хойд талаас хархад үндсэн өнгөнөөс ялгарч харагдах ба цагаан ба мөнгөлөг өнгөтэй тээврийн хэрэгслийн хувьд:
 - a) Хамгийн багадаа 22м- ын өргөнтэй
 - b) Авто хэрэгслийн их биеийн хамгийн доод хэсгээс газрын гадаргын дээд цэг хүртэл босоо шугамын дагуу хэмжихэд 300мм-н зайтай байгаа бол
 - c) Хойно дурдах 119 –р зүйлд заагдсан тусгай тэмдэглэгээний самбараас бусад
- 6) 33-н /5/-р заалтын дэд заалт "а" авто тээврийн хэрэгслийн өргөний хэмжилтэд дугуйны гулгалтаас хамгаалсан аливаа тоноглол ,дугуйн хийн тохируулалтын системийн тоноглол,нэмэлт гэрэл ,дугуйн хийн даралт хэмжигч ,толь,дохиоллын төхөөрөмж,ойлгогч толь зэргийг тооцоогүй болно.

34. Дуут дохио ба дохиоллын систем

- 1) Моторт авто тээврийн хэрэгсэл нь шаардлагатай дуут дохиоллын систем ба бусад дохиоллын системээр тоноглогдсон байж хангалттай хэмжээний дуут дохиогоор бусад тээврийн хэрэгсэлд сэрэмжлүүлэх,эгнээ байршилаа солих үед хэрэглэнэ.
- 2) Моторт авто тээврийн хэрэгсэлийн дуут дохио нь автомат давтамжтай ,шүгэл дохиотой,хонх дуутай ,яндан шүгэл,өндөр даралтын бүрээ дуутай байхыг хориглоно.
- 3) Доорхи нөхцөлд 34-н /2/-р заалтад хамаарахгүй :
 - a) Цагдаагын байгууллагийн эсвэл
 - b) Тусгай зориулалтын эсвэл
 - c) Албан ажлын шаардлагаар
 - d) Тусгай хамгаалалтын албаны зорилгоор эсвэл
 - e) Хил гаалын тусгай зориулалтын эсвэл
 - f) Агаарын тээврийн тусгай зориулалтын эсвэл

- g) Хэрвээ тээврийн хэрэгсэл нь 25 жил хүртэлх насжилттай бөгөөд үргэлжлүүлэн цагдаагийн болон түргэн тусламжын хэрэгцээнд ашиглаж байгаа эсвэл :
 - i. Үзэсгэлэнгийн зориулалтаар ашиглаж байгаа эсвэл
 - ii. Цагдаагийн ба яаралтай түргэн тусламжын тээврийн хэрэгслийн цуглуулгад ашиглаж байгаа
- h) Хэрвээ тээврийн хэрэгсэл нь асах үед хамгаалалтын дохиолол нь ажилладаггүй бол
- 4) Моторт авто тээврийн хэрэгсэл нь энгийн дуут дохиотой бөгөөд ухрах ба ухарах араанд шилжих үед давтамжтай анхааруулах дохиолол өгдөг байж болно.
- 5) Авто тээврийн хэрэгслийн дуут дохиолол нь жолоочын бүхээг ба тээврийн хэрэгслийн ойролцоох хүн ба ойролцоох тээврийн хэрэгслийн жолоочид сонсогдохуйц чанга байна.

35. Арын толь

- 1) Арын толь нь ба толинууд нь энэхүү стандартын шаардлагад нийцсэн байж авто тээврийн хэрэгсэл жолоодогчид ард зорчиж яваа хүн ба тээврийн хэрэгсэл бусад байгууламж объектын ойсон дүрсийг чөлөөтэй харуулахуйцаар хийгдсэн байна.
- 2) Хамгийн багадаа нэг ширхэг арын толь тээврийн хэрэгсэлд байх шаардлагатай :
 - a) Бүх төрлийн автомашин мөн
 - b) Бүх төрлийн моторт 3 дугуйт тээврийн хэрэгсэлд мөн
 - c) Бүх төрлийн моторт мотоцикл ба урдаа нэг хөтлөгч дугуйтай 3 дугуйт мотоцикл ба тэдгээр нь 1976 оны 7 сараас өмнө үйлдвэрлэгдсэн бол
- 3) Хоёр талдаа хамгийн багадаа нэг хэг ширхэг арын толиор тоноглогдсон байх тээврийн хэрэгсэлд:
 - a) Моторт авто тээврийн хэрэгслийн бүрэн жин нь 3.5тонн –оос их эсвэл
 - b) Мотоцикл ,моторт 3 дугуйт урдаа нэг хөтлөгч дугуй бүхий ба 1976 оны 7 сараас өмнө үйлдвэрлэгдсэн бол
- 4) Моторт авто тээврийн хэрэгсэлийн бүрэн жин нь 3.5тонноос их /3 ба 2-р заалтаас бусад авто тээврийн хэрэгсэл багтана./байх тээврийн хэрэгсэл нь :
 - a) Хамгийн багадаа нэг арын толийг тээврийн хэрэгслийн баруун талд суурилуулсан байна.
 - b) Хамгийн багадаа нэг арын толийг тээврийн хэрэгслийн зүүн талд эсвэл дотор суурилуулсан байна.
- 5) Авто тээврийн хэрэгслийн бүрэн жин нь 3.5 тонн-оос их бүхий тээврийн хэрэгсэл нь өөрийн өргөнөөс 150мм хүртэлх гадагших/ гэрэл , дуут дохио ,цацруулагч зэргийг оруулаад / бусад тээврийн хэрэгсэл ба объектыг тусгах боломжтой байна.
- 6) Мөн тээврийн хэрэгслийн арын толийн тусгал их биеийн өргөн хэсгээс гадагш 230мм хүрэхгүй эсвэл их биеийн хэсгийн илүү гарсан бусад нэмэлт хэсгээс 150мм-ээс илүү тусгах боломжгүй байж болно

36. Арын толь –гадаргуу

- 1. Тээврийн хэрэгслийн бүрэн жин 3.5 тонн –оос илүү авто тээврийн хэрэгслийн хоёр талын арын толь нь хамгийн багадаа 150см² талбайтай байна.
- 2. Тээврийн хэрэгслийн бүрэн жин 3.5 тонн –оос илүү авто тээврийн хэрэгслийн зөв талын арын толь дараах нөхцөлд заавал хавтгай ойлгох гадаргуутай байна Үүнд :
 - a) Тээврийн хэрэгсэл нь урдаа ганц хөтлөгчтэй бол

- b) Тээврийн хэрэгслийн хөтлөгчийн удирдлагийн төв нь баруун талдаа эсвэл баруун талтай нэг шугам дагуу байрладаг
- 3. Мопед ба мотоцикл нь хэрвээ арын толийг цацруулагч бүхий хийх бол дараах шаардлага хангана:
 - a) Арын толинууд нь яг ижил муруйлттай байна
 - b) Хэрвээ гүдгэр толь бол ойлголтын гадаргуун нийт радиус хамгийн багадаа 1.2м байна.

37. Нэмэлт арын толь

Моторт авто тээврийн хэрэгсэл нь нэмэлт арын толиор тоноглогдсон байж болох ба тэдгээр нь энгийн хавтгай гадаргуутай эсвэл гүдгэр эсвэл хавтгай гүдгэр толь хослуулан хийсэн байж болно.

38. Автомат хурдны хайрцаг

1. Моторт авто тээврийн хэрэгсэлийн автомат хурдны хайрцаг нь заавал хөдөлгүүр асаах механизмтай байх ба тэр нь хурдны хайрцаг ажиллаж байгаа үед тэр нь автоматаар салгагддаг байна.
2. 1975 оноос хойш үйлдвэрлэгдсэн автомат хурдны хайрцаг бүхий авто тээврийн хэрэгсэл жолоодлогийн үед хурдны хайрцагын удирдлагын байрлалдаа хурдны хайрцагын индикатор /илэрхийлэгч/ бүхий байна.
3. Дээрхи 38-н /1/ ба /2/-д хамаарахгүй тээврийн хэрэгсэл нь хамгийн багадаа 4 –оос илүү дугуйтай байна.

39. Дизель хөдөлгүүр

Моторт авто тээврийн хэрэгсэл нь өөрийн хүч техникийн шаардлагад нийцсэн дотоод шаталтын хөдөлгүүр/ДШХ/ бүхий байна. ДШХ нь мөн өөрөө автоматаар асах ,санамсаргүйгээр асахаас сэргийлэх урьдчилсан хамгаалалтын тоноглол бүхий байна.

40. Моторын хавхаг ,кузов ба хамгаалалтын тоноглол

- 1) Моторт авто тээврийн хэрэгсэл нь өөрийн урд салхины шилнээс урагших моторын ба ачааны хэсэг ,мөн баттерейн хэсгийг бүрэн бүрж хамгаалах зориулалт бүхий их биеийн хөдөлгөөнт бүрхүүл хэсгүүд /копут,хаалга бүрхээр/ бүхий байна.
- 2) Хэрвээ тээврийн хэрэгслийн нээгддэг хэсэг нь нээгдсэн байдалдаа жолоочын урд салхины шилийг бүрэн ба хэсэгчлэн хаадаг бол тэр нь анхдагч ба хоёрдогч хамгаалах тусгай төхөөрөмжтэй байна.

41. Цахилгаан тоног төхөөрөмж,утас,холболт

1. Авто тээврийн хэрэгслийн цахилгаан тоног төхөөрөмж ба өндөр хүчдэл дамжуулах цахилгаан утаснаас бусад цахилгаан утас холболт нь:
 - a) Цахилгаан утасны нийт дамжуулах урт нь 600мм –ээс илүүгүй байх эсвэл тээврийн хэрэгсэл нь нэмэлт чиргүүлтэй бөгөөд түүний уртыг өөрчлөх боломжтой эсвэл сунаж агшдаг чиргүүлтэй байх
 - b) Чиргүүлийн цахилгаан тоноглол нь тусгаарлагдсан байх
 - c) Тэдгээр нь
 - I. Хэт халалт өгдөггүй
 - II. Хөдлөгөөнтэй хэсгүүдтэй шүргэлцдэггүй эсвэл хүрэхээргүй

III. Түлшний хэсэгийн ойр орчимд гал авалцуулах боломжтой газар байрлахгүй

d) Цахилгаан тоног төхөөрөмжийн гадар хамгаалалт ,утасны тусгаарлагч бүрхүүл нь элэгдэл үрэлтээс хамгаалагдсан байх

2.Моторт авто тээврийн хэрэгсэл ба түүний чиргүүлийн цахилгаан электрон тоноглол тэдгээрийн холболт ,зорчих үеийн гэрэлтүүлгийн шаардлага нь Австралийн авто тээврийн хэрэгслийн цахилгаан тоног төхөөрөмжийн холболтын стандарт AS 2513-1982 -д үндэслэв

3. Тээврийн хэрэгслийн чиргүүл нь цахилгаан дамжуулагч тусгай утсаар тоноглогдсон байна.Чиргүүлийн цахилгааны бие даасан монтаж /холболт/ нь чиргүүл ба чирэгч машины бие даасан цахилгаан хэлхээ хооронд эргэн буцах замаар бүрэн хангадаг байна.

4.Бүх төрлийн чиргүүл,хагас чиргүүл,трайллер,авто вагоны зэргийн нийт урт нь 19м-ээс илүү эсвэл 1998 оноос хойш үйлдвэрлэгдсэн бол тэдгээрийн цахилгаан тоног төхөөрөмж ба цахилгаан дамжуулах утас нь Австралийн хийцийн /дизайны/ журамын гурав дахь хэвлэлд тусгайлан зааснаар хэрвээ 1998 оноос өмнө үйлдвэрлэгдсэн бол тухайн тээврийн хэрэгслийн харгалзах ангилалд тавигдсан шаардлагад нийцсэн байна.

42. Телевизор хүлээн авагч ба видео дүрст мэдээ дамжуулах тоноглол

1.Тээврийн хэрэгслийн телевизор хүлээн авагч ба видео дүрст мэдээ дамжуулах хэрэгсэл тэдгээрийн дэлгэц нь жолооч тээврийн хэрэгслийг жолоодон явах энгийн байрлалд харагдхааргүйгээр суурилагдсан байна.

2. Хэрвээ 42-н /1/-р заалтыг хэрэглэхгүй бол тэдгээр нь :

a) Телевизор хүлээн авагч ба видео дүрслэл үзүүлэх дэлгэц нь тээврийн хэрэгслийг хөдөлөх үед ажиллах боломжгүй байна.

b) Жолоочын удирдах самбарын туслах хэрэгсэл болгон ашиглаж байгаа эсвэл нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол буудлыг үзүүлэх зорилготой бол

Жолоочын удирдах самбарын туслах хэрэгсэлд:

- Замын хаагдсан хэсгийг үзүүлэх камер
- Тохируулагч систем
- Чиглэл заагч /навигацын / ба тээврийн хэрэгслийн автомат жолоодлогын ба хурдны замын автомат жолоодлогын системийн тоноглол.
- Арын хэсгийг үзүүлэх дэлгэц
- Тасалбар түгээх төлбөр хураах тоноглол
- Тээврийн хэрэгслийн хяналт мониторингийн тоноглол /GPS/

3.Тээврийн хэрэгслийн телевиз хүлээн авагч ба видео тоноглол тэдгээрийн дагалт тоног төхөөрөмж нь тээврийн хэрэгслийн тухайн хэсэгт найдвартай суурилагдсан байж:

a) Жолоочын явах замын хэсгийг товч тодорхой ойлгогдхоор үзүүлдэг байна

b) Тээврийн хэрэгслийн доторх зорчигчын аливаа хөдөлгөөнд халхлагдхааргүй байна.

43. Салхины шил ба цонх

1. Авто тээврийн хэрэгслийн цонх салхины шил мөн зорчигчын бүхээг тусгаарлагч нь өнгөгүй тунгалаг нэвт харагдах зөвшөөрөгдсөн материалаар хийгдсэн байж тэрхүү материал нь :

а) Авто тээврийн хэрэгсэл нь 1953 оноос өмнө үйлдвэрлэгдсэн

б) Тухайн материал нь 1953 оноос өмнө үйлдвэрлэгдсэн бол

2. Энэхүү заалтын зөвшөөрөгдсөн материал гэдэгт дараах стандарт шаардлагуудад дурдсан ижил технологи үзүүлэлт бүхий материалыг мөн хамруулж ойлгоно:

- Австралийн стандарт AS R1 -1965 “Авто тээврийн хэрэгслийн хамгаалах шилний шаардлага стандарт”
- Австралийн стандарт AS R1 -1968 “Авто тээврийн хэрэгслийн хамгаалах шилний шаардлага стандарт”
- Австралийн стандарт AS 2080-1977 “Авто тээврийн хэрэгслийн аюулгүйн шилний стандарт
- Британи стандарт BS 857:1967 “авто тээврийн хэрэгслийн аюулгүйн шилний стандарт “
- Британи стандарт BS AU 178:1980 “авто тээврийн хэрэгслийн аюулгүйн шилний стандарт “
- Японы үйлдвэрлэлийн стандарт JIS R 3211-1979 “Авто тээврийн хэрэгслийн хамгаалах шилний стандарт “
- Америкийн үндэсний стандарт ANSI Z 26.1-1980 “Хамгаалах аюулгүйн шилэн материалын стандарт авто замаар зорчих авто тээврийн хэрэгслийн аюулгүйн шилний стандарт “

Тунгалаг шилэн материал гэдэгт шилний гадаргууд нэмэлт түрхсэн ба наасан тусгай давхаргыг хамааруулахгүй ба үйлдвэрлэлийн түвшинд ялгагдсан хэсгийг хамааруулахгүй юм

44. Шилний будалт

1. Авто тээврийн хэрэгслийн салхины шилний гадаргийн боловсруулалтад шилний гэрэл нэвтрүүлэх чанар хамгийн багадаа:

а) Авто тээврийн хэрэгсэл нь 1971 оноос өмнө үйлдвэрлэгдсэн бол –75%

б) Бусад тээврийн хэрэгсэлд –70%

2. Авто тээврийн хэрэгслийн салхины шилний гадаргуугын аливаа боловсруулалт нь түүний гэрэл нэвтрүүлэх чадварыг бууруулахгүй байна.

3. Хэрвээ 44-н /1/ ба /2/-р заалтын шаардлагад нийцэхээргүй /том/ зарим төрлийн салхины шил нь :

а) Салхины шилний илүү гарсан тухайн хэсэгт шил арчигчын арчуур бүрэн хүрдэг байх

б) Салхины шилний нийт талбайн 10% хувиас илүү байх

4. Салхины шилэнд ба бүхээг тусгаарлах шилэлгээнд ашиглаж буй тунгалаг материал нь хамгийн багадаа 75% -иас багагүй гэрэл нэвтрүүлэх чадвартай байна..

5 Тээврийн хэрэгслийн арын суудлыг тусгаарласан тусгаарлагч материал нь хамгийн багадаа 35%-н гэрэл нэвтрүүлэх чадвартай байна.

6. Тээврийн хэрэгслийн жолоочын суудалын хажуу ба урд хойд салхины шилний гэрэл нэвтрүүлэх чанар нь 70%-иас ихгүй байх ба бусад хууль дүрэмд гэрэл нэвтрүүлэх чанарыг дээр дурдснаас бага байхаар зөвшөөрсөн бол тэр нь

а) Бусад хуулийн заалтад гэрэл нэвтрүүлэх чанарыг бага байхыг зөвшөөрсөн байж

б) Хамгийн багадаа 35% иас багагүй байна.

7. Шилэн материалын гадаргуугын гэрэл нэвтрүүлэх чанарыг бууруулах аливаа нэмэлт боловсруулалт хийгдээгүй байх ба гэрэл буцааж ойлгох чанар нь 10% -иас бага байна.

8. Салхины шилэнд ашиглаж байгаа материал нь гэрэл нэвтрүүлэх чадвараар дээр дурдсан 44-н /6/, /5/- г хангахгүй байгаа бол үүнтэй эн тэнцэх бусад стандарт шаардлагад дурдсан салхины шилний гэрэл нэвтрүүлэх чанарын тухайн заалтад нийцсэн байна.

9. Дээр дурдсан заалтуудад

Шилэн материал : тээврийн хэрэгслийн жолооч ба зорчигчид урд ба хойд хажуугын ба нэмэлт цонхнууд, тусгаарлах бүхээгт суурилагдаж ойр орчимыг чөлөөтэй харж болохуйцаар хийгдсэн үйлдвэрлэлийн шатанд гадаргуугын нэмэлт ямар нэг боловсруулалт хийгдээгүй шилэн материалыг хэлнэ.

Гэрэл нэвтрүүлэх чанар : Шилэн материал дээр гэрэл тусах үед гэрлийн нийт урсгалын хэдэн хувийг нэвтрүүлж байгааг физик тооцооллоор /фотометр/ хэмжиж нийт туссан гэрлийн хэдэн хувийг нэвтрүүлж байгааг хувьлаж тооцсоныг хэлэх ба тодорхой хэмжээний гэрлийг нэвтрүүлэх чадваргүй бол шаардлагад нийцэхгүй байхаар стандартчлав

45. Салхины шил арчигч ба шил угаагч

1. Гурав ба түүнээс дээш дугуйтай авто тээврийн хэрэгсэл нь дор хаяж нэг салхины шил арчигчтай байх эсвэл жолооч нь тээврийн хэрэгсэл жолоодон явах энгийн байрлалдаа урдах замын хэсгийг урд салхины шилээр харах боломжгүй үед ч чөлөөтэй харж болохуйц байна

2. Хамгийн багадаа нэг ширхэг шил арчигчтай байх тээврийн хэрэгсэл нь :

- а) Жолоочын урдах салхины шил нь нойтон байх үедээ жолооч нь урдах замын хэсгийг чөлөөтэй харах боломжтой байх ба шилний тухайн хэсгээс усыг бүрэн гүйцэд салгах боломж бүхий байна.
- б) Жолоочын хэвийн байрлалдаа тээврийн хэрэгслийг бүрэн жолоодох боломж бүхий байна.
- с) 1934 оноос хойш үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл нь салхины шил арчигч нь зогссон үед жолооч тээврийн хэрэгслийг жолоодон явах боломж бүхий байна.
- д) 1959 оноос хойш үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгслийн хэвийн жолоодлогийн байрлалаас аль ойрхон талд байгаа ба бусад нь
 - i. Жолоочийн байрлалын тухайн хэсгийн салхины шилийг бүрэн ус ба шингэн зүйлээс салгах боломжтой байх мөн тээврийн хэрэгслийн бусад шаардлагатай салхины шил нь жолоочын хэвийн байрлал дахь жолоодлогын үед нойтон байсан ч үзэгдэх боломжоор жолоочын бүрэн хангадаг байна.
 - ii. Салхины шил арчигч нь хөдөлгүүрийн вакум хоолойгоор ажилладаг бол – ус хадгалах шахах вакум хоолой, усны сав, ус шахах компрессор зэргээр тоноглогдсон байж шил арчигч ба ус шахах төхөөрөмж зэрэг нь хоорондоо үр ашигтайгаар авто машины хөдөлгөөнтэй авцалдаатайгаар хийгдсэн байна.

3. Хэрвээ тээврийн хэрэгсэл нь 1982 оноос хойш үйлдвэрлэгдсэн бөгөөд тээврийн хэрэгсэлийн бүрэн жин нь 4.5 тонноос илүү бол заавал салхины шил арчигч ба угаагчаар

тоноглогдсон байх ба шил арчигч нь хөдөлж байх хугацаанд ус шүршигч нь тодорхой үечлэлтэйгээр усыг арчих гадаргууд жигд тараахаар тоноглогдсон байна.

Жич : Австралийн хийцийн ерөнхий шаардлагад/ADR/ тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5тонн-оос илүү бүхий бол завал салхины шил арчигч ба угаагчаар тоноглогдсон байна

4. Салхины шил угаагч нь хэвийн жолоодлогын нөхцөлд бүрэн ажиллах боломжтой байна.

46. Дугуй ба Дугуйн гадар хамар хэмжээ ба даац

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн дагуу тээврийн хэрэгслийн бүрэн жин ба ашиглалтын нөхцөлд тохирсон дугуй ба дугуйн гадар хамарийг суурилуулсан байна Дугуй нь авто тээврийн хэрэгслийн гол дээрх нийт жинг газарт нэгэн жигд тараахаар зохицуулагдан хийгдсэн байна.

47. Хийт дугуй түүний ерөнхий шаардлага

1932 оноос хойш үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл нь заавал хийт дугуйгаар тоноглогдсон байна.

48. Хийт дугуй-- Араг биеийн тогтолцоо /Обудь/

1.Авто тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5 тонноос их бүхий тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг дээр суурилагдсан хийт дугуйн араг бие /обудь/ нь заавал нэгэн ижил байна.Зарим тохиолдолд дугуй нь ижил хэмжээ даацтай боловч адилгүй төрлийн төмөрлөг утсаар хийгдсэн эсвэл өөр өөр хээтэй байж болно

2.Хэрвээ 48-н "1"-г баримтлах боломжгүй бол тэр нь зайлшгүй бөгөөд аюултай нөхцөл байдал үүссэн үед түр зуур ашиглах зориулалтаар өөр хэмжээтэй дугуйг ашигласан байж болно.

49. Хийт дугуйн хэмжээ ба даац

Хийт дугуй бүхий авто тээврийн хэрэгсэл нь өвлийн хүйтний даралтын тэсвэрлэх хэмжээ нь дор дурдсанаас бага байх эсэхийг нэн тэргүүн шийдвэрлэсэн байна

- a) Тухайн хийт дугуйн үйлдвэрлэгч нь дугуйн хүйтэн тэсвэрлэх даралтыг бүрэн тодорхойлсон
- b) Тэсвэрлэх даралт нь
 - i. Энгийн хөндлөн ширээстэй дугуй 825 килопаскал
 - ii. Бусад дугуйнд 700 килопаскал

50. Дугуйн дефект

Авто тээврийн хэрэгслийн дугуй нь үйлдвэрлэлийн ба бусад ямар нэг дефект дутагдалгүй стандарт шаардлагад нийцсэн байх ёстой.

51. Тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5 тонн-оос их бүхий тээврийн хэрэгслийн дугуй

1. Бүрэн жин нь 4.5 тонн их тээврийн хэрэгслийн дугуй нь авто замаар тээврийн хэрэгсэл зорчиход ая тухтай байж ашиглалтын үед :
 - a) 100 км цагт туулах боломжтой байж
 - b) Тээврийн хэрэгслийн дээд хурдаар зорчих боломж бүхий байна.
2. Энэхүү журамд дурдагдсан тээврийн хэрэгслийн дугуйн ашиглалтын хурд ба бусад стандарт шаардлага нь холбогдох Австралийн хийцийн журамд нийцсэн байна.

52. Дугуй-- үйлдвэрлэлийн үнэлгээ

1. Энэхүү стандартыг үндэс болгох тээрийн хэрэгсэлүүдэд :
 - a) 4 ба түүнээс дээш дугуй бүхий
 - b) 1972 оноос хойш үйлдвэрлэгдсэн
 - c) Тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5 тонноос ихгүй
2. Энэхүү журамыг үндэс болгон баримтлахгүй тээврийн хэрэгсэлийн дугуй нь
 - a) Тухайн тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгч нь тээврийн хэрэгсэлийн хязгаарлагдмал хэрэгцээнд тохиромжтой байхыг санал болгосон онцгой нөхцөл байдал үүссэн үед энэхүү журамын "3"-р заалтад заасан хурднаас бага байгаа бол
 - b) Онцгой нөхцөл байдал үүссэний улмаас түр хугацаанд ашиглаж байгаа
3. Тухайн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн шатанд дугуйг анхлан угсарч хэрэглээнд нийцэх эсэхийг бүрэн магадлаж ашиглалтын байдалд үнэлгээ өгсөн байна .Үүнд
 - a) Зорчих хурд нь хамгийн багадаа
 - i. Авто замаар зорчих тусгай зориулалттай тээврийн хэрэгслийн хувьд 140 км/ц
 - ii. Бусад тээврийн хэрэгсэл 180 км/ц эсвэл
 - iii. Бусад моторт тээврийн хэрэгсэл 120 км/ц
 - b) Тээврийн хэрэгслийн дээд хурд жишээлбэл "а)" -н "i" –заалтад хамаарах бүх 4 дугуйт тээврийн хэрэгсэл
4. Жич : Австралийн хийцийн ерөнхий шаардлагад/ADR/ тээврийн хэрэгслийн дугуйн даац ба зорчих дээд хурдын хэмжээг давхар хангасан байна

53. Дугуйнд шинэ бүрээс хийх /бүрэх /

- 1) Тээврийн хэрэгслийн дугуй нь энэхүү журамд заагдсан нөхцөл батлагдаж мөрдөгдөхөөс өмнө дугуйн гадарын боловсруулалт хийгдсэн /дугуйн гадаргын халуун боловсруулалт хийгдсэн / бол тэрхүү тээврийн хэрэгслийн дугуй нь :
 - a) Австралийн стандарт AS 1973-1976 Нийтийн тээврийн ба хөнгөн бага оврын тээврийн хэрэгслийн гадар хээнд дахин боловсруулалт хийх дугуйн стандарт үзүүлэлтэд нийцсэн байх
 - b) Эсвэл тухайн дугуй нь Австралийн стандартад дугуйг дахин боловсруулалт хийх стандарт журам батлагдаж мөрдөгдөөгүй байхад боловсруулалт хийж ашиглаж эхэлсэн бол
 - c) Эсвэл тээврийн хэрэгслийн ашиглаж буй дугуйн хээний боловсруулалт нь Австралийн стандарт AS 1973-1976 Нийтийн тээврийн ба хөнгөн бага оврын тээврийн хэрэгслийн гадар хээнд дахин боловсруулалт хийх дугуйн стандарт, Австралийн стандарт AS 1973-1985 Нийтийн тээврийн ба хөнгөн бага оврын тээврийн хэрэгслийн гадар хээнд дахин боловсруулалт хийх дугуйн стандарт мөн Австралийн стандарт AS 1973-1993 нийтийн тээврийн ба хөнгөн бага оврын тээврийн хэрэгслийн дугуйн дахин боловсруулалт нөхөн сэргээх технологийн стандартын дагуу хийгдсэн байх болно
2. Тээврийн хэрэгслийн ашиглаж буй дугуй нь энэхүү журам балтагдсны дараа боловсруулалт хийгдсэн бол

- a) Австралийн стандарт AS 1973-1993 нийтийн тээврийн ба хөнгөн бага оврын тээврийн хэрэгслийн дугуйн дахин боловсруулалт нөхөн сэргээх технологийн стандартыг үндэслэл болгон мөрдөх
- b) Эсвэл тээврийн хэрэгслийн дугуй нь Австралийн стандарт журмын дагуу боловсруулалт хийгдээгүй

Жич : Австралийн хийцийн ерөнхий шаардлагад/ADR/ тээврийн хэрэгсэлд дахин боловсруулалт хийсэн дугуйг ашиглалтын дээд хурдаар ялгаварлан ангилсан бөгөөд зарим тохиолдолд дахин боловсруулалт хийсэн дугуйн ашиглалтын хурдыг багасган тооцсон болно

54. Дугуйны хээ

1. Авто тээврийн хэрэгслийн замтай тулах /үрэлцэх хэсэг/ хэсэг нь нэгэн жигд байж хооронд завсар дундуур элдэв зүйл хавчуулагдах нь замын гадаргуу хэсэгт хэсэгт зүй бус үйлчлэл үзүүлэх аюултай юм.

2. Дугуйны хээний үрэгдэлтийн индикатораас гадна тээврийн хэрэгслийн ашиглаж буй дугуйн хээ нь замтай үрэлцэх зузаан хамгийн багадаа 1.5 см –аар тасралтгүйгээр үрэлцэх явдал юм.

a) Хөндлөнгөөр

- i. Тээврийн хэрэгслийн бүрэн жин 4.5 тонн-оос их бол хамгийн багадаа дугуйн нийт өргөний 75%-н нь замтай бүрэн харилцан үйлчлэлцэнэ эсвэл
- ii. Бусад төрлийн тээврийн хэрэгсэл дугуйн өргөний хэвийн хэмжээгээр замын тухайн хэсэгтэй үрэлцэлд ордог байна.

b) Дугуй нь бүрэн эргэлтэнд орохдоо бүх хэсгээрээ үйлчлэлцэнэ

3. Тээврийн хэрэгсэлийн дугуй хийхэд ашиглаж байгаа хаймр нь үйлдвэрлэлийн боловсруулалтаас гадна нэмэлт хуулалт зоролт , халуун наалт хийгдсэн зузааны өөрчлөлттэй байхыг хориглоно. Үгүй бол дугуй нь


- a) Тусгай хэрэглээнд зориулагдсан хэт зузаан ,хаймер нь нэмэлт боловсруулалт хийхэд зориулагдсан бөгөөд
- b) Хэрэглээний ба нэмэлт боловсруулалтын ашиглалтын нөхцөлийг дугуйн дээр бичсэн байх.

2-р Хэсэг Нэмэлт Шаардлага Мотоцикл

55. Залуурын механизм ба Жолоо

- 1) Мотоциклийн гар жолооны өргөн нь хамгийн багадаа 250 мм хүртэл сунадаг байж хамгийн ихдээ 450мм –ээс хэтрэхгүй ба хоёр тал эн тэнцүү хувааж мотоциклийн тэнхлэгтэй тэгш хэмтэй байхаар тохируулсан байна.
- 2) 1-р заалтад дурдсан хэмжээг тооцоход толь ба гэрэл бусад нэмэлт тоноглолын уртыг тооцоонд оруулж тооцохгүй
- 3) Мотоциклийн гар жолоонд суурилагдсан базуур нь гар жолоонд суурилагдсан бусад нэмэлт тоноглолоос хамгийн багадаа 380мм –ээс илүү өндөржилттэй байж болохгүй.
- 4) Мотоциклийн гар жолооны хоёр талд суурилагдсан тоормосны базуур нь жолооны гартай ба хоорондоо тэгш хэмтэй суурилагдсан байна.

- 5) Хэрвээ мотоциклийн толгой хэсэг нь урд жолоодлогийн тулгуур цэгт шууд тулж байгаа бол урд дугуйн голын тэнхлэг ба жолооны гол холхивчын тэнхлэгүүдийн босоо перпендикуляр хоорондын зай нь 550мм –ээс ихгүй байна.



56.

гишгүүрүүд

Мотоцикл нь жолоочын хэвийн нөхцөл дэх жолоодлогын үед жолоочын ба зорчигчын заасан суудалд хөл амрах тусгай тавцангууд суурилагдсан байна.

57. Гинжний хамгаалалт

- 1) Мотоциклийн хөдөлгүүрийн ард дугуй руу хүч дамжуулах нэгж нь гинжин араат бол түүгээр зорчих үед жолооч ба зорчигч нь урд араа ба урд хэсгийн гинжин дамжуулга нь:
 - а) Араат дамжуулга ба гинж нь хамгаалах хүрээ бүхий байна.
 - б) Гинжний хамгаалалт
- 2) Гинжний хамгаалалт хүрээ нь гинжний :
 - а) Хамгийн багадаа хойд дугуйн хамгий хойд хөл тавих тавцанг хүртэлх 300мм хэсэг мөн
 - б) Урд хэсгийн араат дамжуулгийг хамруулсан байна.

БҮЛЭГ-6 АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУГААРЛАЛТ /МАРКЛАЛТ/

Энэхүү бүлэг нь тээврийн хэрэгслийн хяналт шалгалт ,бүртгэлийн шаардлагийн дагуу бүртгэн тэмдэглэх тусгай дугаарлалтыг хэрэглээнд нэвтрүүлэх зорилготой бөгөөд хэрвээ тухайн тээврийн хэрэгсэл нь удаан хэрэглэгдээгүй ба осол аваарт өртөж байсан зэрэг мэдээллийг архивлан жолоочид анхааруулж байх үүрэгтэй

58. Тээврийн хэрэгсэлийн ба хөдөлгүүрийн дугаар